



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2015 ОНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГО:

НЭГДСЭН ДҮН

УЛААНБААТАР ХОТ
2016 ОН



ДАА 361.311
ННА 60
Х-828



"Соёмбо принтинг" ХХК-д
хэвлэв.

ISBN 978-99973-79-32-0

АГУУЛГА

Зургийн жагсаалт.....	4
Хүснэгтийн жагсаалт.....	5
Хавсралт хүснэгтийн жагсаалт.....	6
ӨМНӨХ ҮГ.....	9
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	11
Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогыг зохион байгуулж явуулсан тухай	
ХОЁРДУГААР БҮЛЭГ	19
Хүн амын тоо, өсөлт, нас, хүйсийн бүтэц	
ГУРАВДУГААР БҮЛЭГ	31
Улсын харьяалал, үндэс угсаа	
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	45
Хүн амын суурьшил, нягтрал	
ТАВДУГААР БҮЛЭГ	55
Өрхийн орон сууцны төрөл, нөхцөл	
ЗУРГАДУГААР БҮЛЭГ	67
Дэлхийн улс орнуудын хүн ам зүйн байдал	
ХАВСРАЛТ	75



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Монгол Улсын хүн амын тоо, 2015 он.....	21
Зураг 2.2.	Хүн амын 1918-2015 оны тооллого хоорондын жилийн дундаж өсөлт, тооллогын онуудаар.....	22
Зураг 2.3.	Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт 1000 хүнд ногдохоор, 2006-2015 онуудаар.....	23
Зураг 2.4.	Хүн амын насны бүтэц, тооллогын онуудаар	25
Зураг 2.5.	Монгол Улсын хүн амын суварга, 2010, 2015 он	26
Зураг 3.1.	Хүн амын тоо, иргэний харьяалалаар, 2015 он.....	33
Зураг 3.2.	Гадаадын харьяат иргэдийн насны бүтэц, хувиар, 2010, 2015 он	35
Зураг 3.3.1.	Казах угсаатны бүлгийн тархалт, аймгаар, 2015 он	38
Зураг 3.3.2.	Дөрвөд угсаатны бүлгийн тархалт, аймгаар, 2015 он	39
Зураг 3.3.3.	Баяд угсаатны бүлгийн тархалт, аймгаар, 2015 он	39
Зураг 3.3.4.	Буриад угсаатны бүлгийн тархалт, аймгаар, 2015 он	40
Хүснэгт 3.5.	Хүн амын тархан суурьшилт, үндэс угсаа, аймаг, нийслэл, хувиар, 2015 он	40
Зураг 3.4.	Хүн амын тоо, үндэс угсаа, хот, хөдөө, хувиар, 2015 он	42
Зураг 4.1.	Хүн амын суурьшлын ерөнхий байдал	51
Зураг 4.2.	Суурин хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2015 он	52
Зураг 5.1.	Өрхийн тоо, сууцны төрлөөр, 2015 он	57
Зураг 6.1.	Хүн амын өсөлтийн хувь, дэлхийн улс орнуудаар	69
Зураг 6.2.	Хүн амын суварга, тивүүдээр, 2015 он.....	70
Зураг 6.3.	Хүн амын суварга, тивүүдээр, 2015 он.....	71
Зураг 6.4.	Хүн амын нягтрал, дэлхийн улс орнууд, 2015 он.....	71
Зураг 6.5.	Дундаж наслалт, дэлхийн улсуудаар, 2011-2015 он	72
Зураг 6.6.	Төрөлтийн ерөнхий коэффициент, тив улсуудаар, 2015 он.....	72

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.	Монгол Улсын хүн амын тоо, тооллого явагдсан оноор	21
Хүснэгт 2.2.	Аймаг, нийслэлийн хүн амын өсөлт, хувиар 1989-2015 он.....	24
Хүснэгт 2.3.	Хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хүйсийн харьцаагаар, 2010, 2015 он	25
Хүснэгт 2.4.	Аймаг, нийслэлийн хүн амын тоо, хүйс, хүйсийн харьцаагаар, 2010, 2015 он	27
Хүснэгт 2.5.	Хот, хөдөөгийн хүн амын тоо, хүйс, хүйсийн харьцаагаар, 2010, 2015 он	28
Хүснэгт 2.6.	Хүн амын тоо, хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, 2015	28
Хүснэгт 3.1.	Монгол улсад оршин суугаа гадаадын харьяат иргэдийн тоо, аймаг, нийслэл, хувиар, 2010, 2015 он	34
Хүснэгт 3.2.	Монгол Улсын суурин хүн ам, гадаадын харьяат иргэдийн нас, хүйсийн бүтэц, хувиар, 2015 он.....	35
Хүснэгт 3.3.	Монгол улсад суугаа монголын харьяат хүн амын тоо, үндэс угсаа, хувиар, 2010, 2015 он	36
Хүснэгт 3.4.	Хүн амын тоо, үндэс угсаа, насны бүлэг, хувиар, 2015 он.....	37
Хүснэгт 4.1.	Хүн амын тоо, бүс нутаг, өсөлт, хувиар, 2010, 2015 он	47
Хүснэгт 4.2.	Хүн амын тоо, аймаг, нийслэл, өсөлт, хувиар, 2010, 2015 он	48
Хүснэгт 4.3.1.	Хүн амын тоо, бүс нутаг, хот, хөдөө, хувиар, 2015 он.....	49
Хүснэгт 4.3.2.	Хүн амын тоо, бүс нутаг, хот, хөдөө, хувиар, 2010, 2015 он, мян.хүн	49
Хүснэгт 4.4.	Хүн амын тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, хувиар, 2015 он.....	50
Хүснэгт 4.5.	Суурин хүн амын тоо, нягтрал, бүс нутаг, хувиар, 2015 он	51
Хүснэгт 4.6.	Хүн амын тоо, нягтрал, аймаг, нийслэл, хувиар, 2010, 2015 он	52
Хүснэгт 5.1.	Өрхийн тоо, сууцны төрөл, хот, хөдөө, хувиар, 2015 он	58
Хүснэгт 5.2.	Өрхийн тоо, сууцны төрөл, хувиар, 2010, 2015 он.....	58
Хүснэгт 5.3.	Өрхийн тоо, сууцны төрөл, байршил, хувиар, 2015 он.....	59
Хүснэгт 5.4.	Өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, хот, хөдөө, хувиар, 2015 он	59
Хүснэгт 5.5.	Өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, хот, хөдөө, хувиар, 2015 он.....	60
Хүснэгт 5.6.	Гэрт амьдардаг өрхийн тоо, гэрийн ханын тоо, хот, хөдөө, хувиар, 2015 он	61
Хүснэгт 5.7.	Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн зарим үзүүлэлт, хот, хөдөө, хувиар, 2015 он	61
Хүснэгт 5.8.	Байшинд амьдардаг өрхийн тоо, сууцны талбайн хэмжээ, хот, хөдөө, хувиар, 2015 он	62
Хүснэгт 5.9.	Байшинд амьдардаг өрхийн халаалтын төрөл, хот, хөдөө, хувиар, 2010, 2015 он	63
Хүснэгт 5.10.	Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн зарим үзүүлэлт, хот, хөдөө, хувиар, 2015 он	63
Хүснэгт 5.11.	Байшинд амьдардаг өрхийн зарим ахуйн нөхцөл, хот, хөдөө, хувиар, 2015 он	64
Хүснэгт 6.1	Хүн амын нас, хүйсийн бүтэц, тивүүдээр, 2014.....	70



ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	Монгол Улсын хүн ам.....	77
Хүснэгт 1.2	Монгол Улсын харьяат хүн амын тоо, аймаг, нийслэл, байршлаар, 2015 он	79
Хүснэгт 1.3	Монгол Улсын харьяат хүн амын тоо, насны бүлэг, хүйс, байршлаар, 2015 он.....	81
Хүснэгт 1.4	Монгол Улсын харьяат хүн амын тоо, аймаг, нийслэлээр, 2015 он.....	82
Хүснэгт 1.4.1	Монгол Улсын харьяат эрэгтэй хүн амын тоо, аймаг, нийслэлээр, 2015 он.....	83
Хүснэгт 1.4.2	Монгол Улсын харьяат эмэгтэй хүн амын тоо, аймаг, нийслэлээр, 2015 он.....	84
Хүснэгт 1.5	Монгол Улсын суурин хүн амын тоо, аймаг, нийслэл, байршлаар, 2015 он	85
Хүснэгт 1.6	Монгол Улсын суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйс, байршлаар, 2015 он.....	86
Хүснэгт 1.7	Монгол Улсын суурин хүн амын тоо, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2015 он	87
Хүснэгт 1.7.1	Монгол Улсын суурин хүн амаас эрэгтэй хүн амын тоо, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2015 он	88
Хүснэгт 1.7.2	Монгол Улсын суурин хүн амаас эмэгтэй хүн амын тоо, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2015 он	89
Хүснэгт 1.8	Монгол Улсын харьяат гадаадад байгаа хүн амын тоо, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2015 он.....	90
Хүснэгт 1.8.1	Монгол Улсын харьяат гадаадад байгаа эрэгтэй хүн амын тоо, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2015 он.....	91
Хүснэгт 1.8.2	Монгол Улсын харьяат гадаадад байгаа эмэгтэй хүн амын тоо, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2015 он.....	92
Хүснэгт 1.9	Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаад хүн амын тоо, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2015 он.....	93
Хүснэгт 1.9.1	Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаад хүн амын тоо, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2015 он.....	94
Хүснэгт 1.9.2	Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаад хүн амын тоо, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2015 он.....	95
Хүснэгт 1.10	Монгол Улсын суурин хүн амын тоо, харьяалал, үндэс угсаа, насны бүлгээр, 2015 он.....	96
Хүснэгт 1.11	Монгол Улсын суурин хүн ам, харьяалал, үндэс угсаа, хот, хөдөөгөөр, 2015 он.....	98
Хүснэгт 1.12.1	Архангай аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	99
Хүснэгт 1.12.2	Баян-Өлгий аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	99
Хүснэгт 1.12.3	Баянхонгор аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	100

Хүснэгт 1.12.4	Булган аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	100
Хүснэгт 1.12.5	Говь-алтай аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	101
Хүснэгт 1.12.6	Дорноговь аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	101
Хүснэгт 1.12.7	Дорнод аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	102
Хүснэгт 1.12.8	Дундговь аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	102
Хүснэгт 1.12.9	Завхан аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	103
Хүснэгт 1.12.10	Өвөрхангай аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	104
Хүснэгт 1.12.11	Өмнөговь аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	104
Хүснэгт 1.12.12	Сүхбаатар аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	105
Хүснэгт 1.12.13	Сэлэнгэ аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	105
Хүснэгт 1.12.14	Төв аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	106
Хүснэгт 1.12.15	Увс аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	107
Хүснэгт 1.12.16	Ховд аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	107
Хүснэгт 1.12.17	Хөвсгөл аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	108
Хүснэгт 1.12.18	Хэнтий аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	108
Хүснэгт 1.12.19	Дархан-Уул аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	109
Хүснэгт 1.12.20	Орхон аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	109
Хүснэгт 1.12.21	Говьсүмбэр аймгийн суурин хүн амын тоо, сум, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	109
Хүснэгт 1.13.1	Багануур дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	110
Хүснэгт 1.13.2	Багахангай дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	110
Хүснэгт 1.13.3	Баянгол дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	110
Хүснэгт 1.13.4	Баянзүрх дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	111



Хүснэгт 1.13.5	Налайх дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	111
Хүснэгт 1.13.6	Сонгинохайрхан дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	112
Хүснэгт 1.13.7	Сүхбаатар дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	113
Хүснэгт 1.13.8	Хан-Уул дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	113
Хүснэгт 1.13.9	Чингэлтэй дүүргийн суурин хүн амын тоо, хороо, хүйс, насны бүлгээр, 2015 он.....	114
Хүснэгт 2.1	Өрхийн тоо, сууцны төрөл, аймаг, нийслэлээр, 2015 он.....	115
Хүснэгт 2.2	Өрхийн тоо, эзэмшил, аймаг, нийслэлээр, 2015 он.....	115
Хүснэгт 2.3	Өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, аймаг, нийслэлээр, 2015 он.....	116
Хүснэгт 2.4	Өрхийн тоо, халаалтын эх үүсвэр, аймаг, нийслэлээр, 2015 он.....	116
Хүснэгт 2.5	Өрхийн тоо, усан хангамж, аймаг, нийслэлээр, 2015 он.....	117
Хүснэгт 2.6	Өрхийн тоо, бохир ус зайлуулалт, аймаг, нийслэлээр, 2015 он.....	117
Хүснэгт 2.7	Өрхийн тоо, хатуу хог, хаягдал зайлуулалтын хэлбэр, аймаг, нийслэлээр, 2015.....	118
Хүснэгт 2.8	Байшинд амьдардаг өрхийн тоо, эзэмшил, аймаг, нийслэлээр, 2015 он.....	118
Хүснэгт 2.9	Байшинд амьдардаг өрх, цахилгааны эх үүсвэр, аймаг, нийслэлээр, 2015 он.....	119
Хүснэгт 2.10	Байшинд амьдардаг өрх, усан хангамж, аймаг, нийслэлээр, 2015 он.....	119
Хүснэгт 2.11	Байшинд амьдардаг өрх, халаалтын эх үүсвэр, аймаг, нийслэлээр, 2015 он.....	120
Хүснэгт 2.12	Байшинд амьдардаг өрх, бохир ус зайлуулалт, аймаг, нийслэлээр, 2015 он.....	120
Хүснэгт 2.13	Байшинд амьдардаг өрх, хатуу, хог хаягдал зайлуулалт, аймаг, нийслэлээр, 2015 он.....	121
Хүснэгт 2.14	Байшинд амьдардаг өрх, сууцны талбай, аймаг, нийслэлээр, 2015 он.....	121
Хүснэгт 2.15	Гэрт амьдардаг өрх, ханын тоогоор, аймаг, нийслэлээр, 2015 он.....	122
Хүснэгт 2.16	Гэрт амьдардаг өрх, цахилгааны эх үүсвэр, аймаг, нийслэлээр, 2015 он.....	122
Хүснэгт 2.17	Гэрт амьдардаг өрх, халаалтын эх үүсвэр, аймаг, нийслэлээр, 2015 он.....	123
Хүснэгт 2.18	Гэрт амьдардаг өрх, бохир ус зайлуулалт, аймаг, нийслэлээр, 2015 он.....	123
Хүснэгт 2.19	Гэрт амьдардаг өрх, хатуу хог, хаягдал зайлуулалт, аймаг, нийслэлээр, 2015 он.....	124

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг Монгол Улсын “Статистикийн тухай”, “Хүн ам, орон сууцны тухай” хууль болон НҮБ-ын зөвлөмжид заасны дагуу 10 жил тутамд зохион байгуулдаг ба нийтдээ 10 удаа ээлжит тооллогыг явуулсан байдаг. Харин завсрын тооллогыг өмнө зохион байгуулсан туршлага байхгүй бөгөөд дээрх зөвлөмж, хуулинд заасны дагуу 2015 онд анх удаагаа зохион байгуулсны сацуу “хүн амын регистрийн бүртгэлд суурилсан бүртгэлийн аргаар” хийлээ. Өөрөөр хэлбэл, засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хороонд хөтлөгддөг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-г төрийн захиргааны бусад байгууллагын мэдээллийн сантай уялдуулан завсрын тооллогын үр дүнг гаргасан юм. Түүнчлэн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдээ интернэтээр тоолон, гадаадын олон орны туршлагад тулгуурлан орон зайн газарзүйн мэдээллийг тооллогын үр дүнтэй холбон ашигласан тооллого боллоо.



Хүн ам, орон сууцны тооллого нь хүн амын тоо, нас хүйсийн бүтэц, угсаатны бүрэлдэхүүн, байршил, орон сууцны төрөл, нөхцөл зэрэг нийгэм, эдийн засгийн дэлгэрэнгүй тоо баримтыг агуулдаг, энэхүү үр дүнг засаг захиргааны анхан шатны нэгжид гаргах боломжтой цорын ганц мэдээллийн эх үүсвэр билээ. Түүнчлэн хүн ам зүйн олон үзүүлэлтүүд, үүний дотор хүн амын суурьшил, байршлыг зөв оновчтой зохицуулах, төвлөрлийг сааруулах талаарх төр засгийн бодлого, хөтөлбөрийг боловсруулахад тооллогын үр дүн чухал ач холбогдолтой юм.

Тооллогын үр дүнг төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд өргөн хүртээмжтэй тархах нь Үндэсний статистикийн байгууллагын эрхэм үүрэг. Тооллогын дүнг улс, аймаг, нийслэлээр төрөлжүүлэн мэдээлэхээс гадна тодорхой сэдвээр гүнзгийрүүлсэн судалгаануудыг хийх шаардлагатай юм. Энэхүү тайлан нь 6 бүлэг, тооллогын нэгдсэн үр дүнгийн гол гол үзүүлэлтээс бүрдсэн хавсралтаас бүрдэнэ.

Тайлангийн 1-р бүлэгт Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын зохион байгуулалт, 2-4 дүгээр бүлэгт хүн амын тоо, өсөлт, иргэний харьяалал, үндэс угсаа, суурьшил зэрэг хүн ам зүйн гол үзүүлэлт, 5-р бүлэгт өрхийн тоо, өрхийн орон сууцны нөхцөл, 6-р бүлэгт дэлхийн улс орнуудын хүн ам зүйн байдлын талаар танилцуулав.

Тооллогын дүнг үндэслэн хүн амын хэтийн тооцоог аймаг, нийслэл, нас, хүйсээр, олон хувилбараар тооцож нийтийн хүртээл болгоно. Тооллогын дүнг хэвлэмэл бүтээгдэхүүнээс гадна онлайн хэлбэрээр өргөн тархах болно.

Энэхүү тайланг бэлтгэсэн Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга А.Амарбал, статистикч Т.Болор-Эрдэнэ, шинжээч Т.Жаргалсайхан, ажилтан М.Энхзориг нар болон тооллогын мэдээлэл боловсруулалт, зохион байгуулалтад хамтран ажилласан Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга Д.Оюунчимэг, Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын ахлах шинжээч З.Нямбаяр, Б.Уранбилэг, Мэдээллийн технологийн газрын дарга Л.Мягмарсүрэн, ахлах референт Ц.Эрдэнэмөнх, ахлах шинжээч Б.Тамир, Г.Жаргал, тооллогын товчооны бүрэлдэхүүнд ажиллаж байсан Ж.Мөнхбадар, Х.Золбадрах нарт талархлаа илэрхийлье.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА

 А.АРИУНЗАЯА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2015 ОНЫ
ЗАВСРЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН
БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТҮҮХЭЭС

Монгол Улс хүн амаа эрт дээр үеэс бүртгэн, тоолж байсан баримт түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн боловч тооллогын хамарсан нутаг дэвсгэрийн хил хязгаар, он, хүн амын тоо нь нэлээд бүрхэг баримжаа төдий байдаг. Бидэнд байгаа баримтаар Хүннү гүрний үед хүн ам, мал тооллого явуулж байсан болон 1247 он буюу IV жарны 41 дэх улаагчин хонь жил “Монгол улс даяар хүн амын тооллого явуулав”¹ гэсэн байна. Манай улс 1921 оны ардын хувьсгалын дараа хүн ам, хөрөнгө малын тоо бүртгэлийг 1922-1940 он хүртэл олон удаа (Бидэнд байгаа баримтаар 1922, 1929, 1933, 1935, 1937, 1939 онуудад) явуулж байсан бөгөөд тэдгээрийн үзүүлэлт нь маш өргөн хүрээтэй (Богд хаант Монгол Улсын үеийнхээс), өрх, хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, малын тоо, малын хашаа саравч, гэрийн бүрээс, хадлангийн болон бусад ажлын багаж хэрэгсэл гэх мэт асуулгыг багтааж байсан аж².

Монгол Улсад хүн амын тооллого ХХ зууныг хүртэл тогтмол явагдаж байгаагүй бөгөөд ХХ зууны анхны тооллого 1918 онд явагдсан байна. Дараа нь 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000, 2010 онуудад ээлжит тооллогыг явуулав. Үүний зэрэгцээгээр 1947, 1950 онуудад хүн амын тооллого шиг нэг удаагийн бүртгэл хийсэн байдаг.

Хүн ам, орон сууцны тооллогыг Монгол Улс ХХ зуунд 9 удаа, ХХI зууны эхний тооллогыг 2010 онд явуулж байсан бол 2015 онд анх удаагаа хүн амын регистрт суурилсан бүртгэлийн аргаар завсрын тооллогыг зохион байгуулаад байна.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7.1-ийн а-д “Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам”, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Завсрын тооллогын тов, үргэлжлэх хугацаа, хамрах хүрээг Үндэсний статистикийн хороо тухай бүр тогтооно” гэж тус тус заасны дагуу Үндэсний Статистикийн Хороо “Хүн ам, орон сууцны завсрын тооллого”-ыг 2015 онд зохион байгуулж, үр дүнг нэгтгэн боловсруулан таницуулж байна.

Үндэсний Статистикийн Хороо нь хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах үүрэг бүхий хороог, тооллогын бэлтгэлийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хангаж, хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-гийн бүрдэлтийг бүрэн дуусгах үүрэг бүхий аймаг, нийслэлийн тооллогын комиссыг тус тус байгуулж ажиллав.

Хүн ам, орон сууцны завсрын тооллого (ХАОСЗТ) батлагдсан үзэл, баримтлалын дагуу хүн ам, өрхийн мэдээллийн санд бүртгэгдсэн хүн амын холбогдолтой 18, орон сууцны холбогдолтой 15 үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт суугаа иргэд /гадаадын болон харьяалалгүй иргэдийг оруулсан/, гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийг хамруулсан.

Энэ удаагийн тооллого нь ээлжит тооллого хооронд явагдсан анхны завсрын тооллого бөгөөд “Хүн амын регистрийн бүртгэлд суурилсан бүртгэлийн арга” буюу Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-г төрийн захиргааны бусад байгууллагын захиргааны мэдээллийн сантай уялдуулснаараа ихээхэн ач холбогдолтой. Мөн гадаадад удаан хугацаагаар амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг интернэтээр тоолсноос гадна Монгол Улсын иргэн ХАӨМС-нд хандан өөрийн мэдээллийг шинэчлэх боломжийг бий болгосноороо онцлогтой болов.

ХАӨМС-г төрийн захиргааны 14 байгууллагын 38 төрлийн мэдээллийн сан, интернэт тооллого, орон гэргүй (тэнэмэл) иргэдийн тооллого, тодруулга хийсэн иргэдийн мэдээллийг уялдуулан Монгол Улсын иргэний хаягийг тодруулах, нас барсан, харьяатаас гарсан эсэх зэргийг нягтлах, сангийн үзүүлэлтийг тодотгох ажлыг зохион байгуулж, шаардлагатай тодотголыг хийж

¹ Монгол Улсын түүх, дэд боть, УБ, 2003 он, 364-р тал

² Монгол Улсын хүн ам зүйн түүхэн товчоо, УБ, 2013 он



ажиллалаа. Хүн ам, орон сууцны завсрын тооллогод өрхийн байршлыг тодорхойлохдоо төв суурин газрын өрхийн хаягийн мэдээллийг кадастрын мэдээллийн сангийн хаягтай тулгах, ХАӨМС-ийн програмд онлайн газрын зураг дээр өрхийн байршлыг нэг бүрчлэн оруулах гэсэн хэлбэрээр тодорхойлж, нийт өрхийг байршлаар гаргав.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хороо. Үндэсний статистикийн хороо Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хороо (цаашид Хороо гэх) байгуулж ажиллав.

Хорооны үйл ажиллагааны зорилго нь хүн ам, орон сууцны завсрын тооллогын бэлтгэл ажлыг хангуулах, үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулж явуулах, үр дүнг нэгтгэн гаргахад нэгдсэн хяналт тавьж, удирдан чиглүүлэх, тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох яам, агентлагуудын болон орон нутгийн комиссын ажлын уялдаа холбоо, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангахад чиглэв.

Хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан баримт бичгийг удирдлага болгон мөрдөж ажиллав.

Аймаг, нийслэлийн тооллогын комисс. Аймаг, нийслэлд тооллогын комисс ажиллах бөгөөд тэдгээрийн зорилго нь Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын бэлтгэлийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хангаж, ХАӨМС-гийн бүрдэлтийг бүрэн дуусгах, тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох байгууллагуудын ажлын уялдаа, холбоог нэгдсэн зохицуулалтаар хангахад оршив.

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны тооллогын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу аймаг, нийслэлийн тооллогын комисс дараах үүрэгтэй байв. Үүнд:

1. Тооллогоор хүн ам, орон сууцны талаарх мэдээллийг цуглуулах ажлыг зохих журмын дагуу тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулах
2. Тооллогын ажилтныг гэрээгээр авч ажиллуулах, шаардлагатай сургалт явуулах, ажлын үр дүнг тооцох
3. Хороо болон Үндэсний статистикийн хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу арга хэмжээ авч ажиллах
4. Тооллогын явц, урьдчилсан дүнгийн мэдээллийн үзүүлэлтийг нэгтгэж, дээд шатны байгууллагад хүргэх

Мэдээлэл цуглуулагч (Гэрээт ажилтан). Завсрын тооллогын мэдээлэл цуглуулагч буюу гэрээт ажилтан нь тогтоосон хугацаанд ХАӨМС-гийн мэдээллийг баяжуулж, бүрдэлтийг бүрэн хийх үүрэгтэйгээр анхан шатны нэгжид 2015 оны 6-р сараас 12-р сарыг дуустал хугацаанд хувь хүний нууцлалыг хангах, шаардлагыг бүрдүүлэх гэрээний дагуу ажиллав.

Гэрээт ажилтан нь иргэн, өрхийн мэдээллийг иж бүрэн шалгасны үндсэн дээр ХАӨМС-д нэгтгэж, өрхийн байршлыг зааврын дагуу тэмдэглэх үндсэн үүрэгтэй байв. Тус ажилтан аймаг, нийслэлийн тооллогын комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр гүйцэтгэж ажиллаж байлаа.

СУРГАЛТ

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын дүнгийн чанарт нөлөөлөх гол үүрэг бүхий ажилтан бол багийн засаг дарга, хороодын зохион байгуулагчид байлаа. Тиймээс хүн ам, өрхийн мэдээллийн сан, түүний хэрэглээг сайжруулах ажлын хүрээнд нийслэл, дүүрэг хороодын засаг дарга болон мэргэжилтэн, зохион байгуулагч нарт зориулсан сургалтыг удаа дараа зохион байгууллаа. Тус албан хаагчид нь өөрсдийн хариуцсан анхан шатны нэгжийн хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулж, алдааг засварлаж ажилласан.

СУРТАЛЧИЛГАА

Тооллогыг амжилттай явуулах, ялангуяа ард иргэдийг тооллогод идэвхтэй бүрэн оролцуулах нь ухуулга сурталчилгааны ажлын үндсэн зорилт байв. Өөрөөр хэлбэл, тооллогод хамрагдахын ач холбогдол, хэрхэн хамрагдахыг ухуулан ойлгуулахад оршиж байв.

Сурталчилгааг телевиз, радио, ФМ зэргээр дамжуулан ярилцлага хийх, бэлтгэгдсэн мэдээлэл байнга өгөх, телевизийн шторк, сурталчилгааны самбар байршуулсан бөгөөд дараах чиглэлийг баримтлан зохион байгуулав. Үүнд:

- Хүн ам, өрхийн бүртгэлийн явцын талаар болон мэдээллийн баяжуулалт, бүртгэлийн ач холбогдол
- ХАӨМС-гийн мэдээллийг баяжуулах, бүртгэлийн ач холбогдлыг таниулах «Нээлттэй хаалганы өдөрлөг»-ийг баг, хороонд нэгдсэн графикийн дагуу холбогдох журмаар зохион байгуулах
- ХАӨМС-д иргэд онлайнаар хандаж, мэдээллээ баталгаажуулах талаарх сурталчилгааны материал боловсруулж тархах зэрэг ажлууд багтаж байв.

Түүнчлэн, иргэн өөрийнхөө мэдээллийг баталгаажуулах, интернэт бүртгэл явуулж, сонирхолтой статистикийг харах байдлаар иргэдийн бүртгэлийг шинэчлэж байв.

ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод газарзүйн мэдээллийн систем (ГМС)-ийг тооллогын нэгжийн байршил тодорхойлохоос гадна тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлох, өрх, хүн амыг тооллогод бүрэн хамруулах гэсэн чухал ач холбогдолтой байсан. Гэхдээ тухайн үеийн нөөц бололцооноос хамаарч зөвхөн цаасан газрын зураг ашиглан тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлох, тоологчийн хариуцах газар нутгийг хуваарилах, тооллогын үеийн төлөвлөлт хийх, тооллогын нэгжийн байршил тэмдэглэж байсан.

Харин 2015 оны завсрын тооллогын үндсэн аргазүйн дагуу бүртгэлд суурилсан өрхийн байршил тодорхойлох шаардлага үүссэн. Үүний дагуу төв суурин газрын өрхүүдийн байршлыг кадастрын мэдээллийн санг ашиглан уг сангийн хаягийн мэдээллийг ХАӨМС-гийн мэдээлэлтэй тулгаж, хаяг нь таарсан өрхийн байршлыг кадастрын мэдээллээр тодорхойлсон (1-р арга). Энэ аргаар тодорхойлсноос үлдсэн өрх буюу хаяг тодорхой бус, хаягийн болон кадастрын мэдээлэл дутуу өрх, хөдөөгийн өрхийн байршлыг ХАӨМС програмд онлайн газрын зураг ашиглан өрхийн байршил тэмдэглэх функц нэмэх байдлаар тодорхойлсон (2-р арга).

Өрхийн байршил тодорхойлох үйл явц: Эхний ээлжинд ХАӨМС дахь өрхийн хаягийг тогтсон стандартын дагуу засварлаж, 3 үзүүлэлт (хороолол/хотхон/гудамжны нэр, байрны дугаар/гудамжны дугаар, хаалганы тоот/хашааны тоот) болгон хуваасан. Энэ ажлын үр дүнд аймгуудын өрхийн 96.6 хувь, нийслэлийн өрхийн 99.7 хувийн хаяг тус тус зассан.

Үүний дараа төв суурин газрын кадастрын мэдээллийг Газрын харилцаа геодези зурагзүйн газраас (ГХГЗЗГ) авсан хэдий ч 10 аймгийн өгөгдөл ашиглах боломжтой буюу хаягийн мэдээлэлтэй байсан. Эдгээр 10 аймгийн кадастрын мэдээллийг ашиглан нийт 13 777 өрхийн байршил тодорхойлсон. Нийслэлийн гэр хорооллын хэсэгт кадастрын мэдээллийг Нийслэлийн газрын албанаас, орон сууцны хэсэгт Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраас барилга орон сууцны мэдээллийг тус тус ашигласан. Эдгээр мэдээллийг ашиглан нийслэлийн 9 дүүргийн гэр хорооллын 129 637, орон сууцны 118 571, нийт 248 208 өрхийн байршил тодорхойлсон.

Ингэснээр 1-р арга буюу кадастр болон хаягийн мэдээлэл ашиглан өрхийн байршил тодорхойлох аргаар 10 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийтдээ 261 985 өрх буюу нийт өрхийн 32 хувийн байршлыг тодорхойлсон.



Үлдсэн өрх буюу нийт өрхийн 68 хувийн байршлыг 2-р аргаар тодорхойлсон юм. ХАӨМС програмд онлайн газрын зураг ашиглан өрхийн байршил тэмдэглэх нэмэлт функц нэмж, уг функцийг ашиглан ХАӨМС-ын анхан шатны хэрэглэгчид өрхийн байршлыг газрын зурагт тэмдэглэсэн. Ингэхдээ нийтийн хэрэгцээнд ашиглагддаг Google map, Bing map, Arcgis map зэрэг онлайн дэлхийн газрын зургуудаас харьцуулалт хийсний үндсэнд Arcgis map-ийг суурь зургаар сонгон авч, ГХГЗЗГ-аас хүлээн авсан 1:100 000 масштабтай байрзүйн зургаас үүсгэсэн газар усны нэршлийг давхарлан ашигласан.

ХАӨМС-ийн анхан шатны хэрэглэгчид болох баг, хорооны засаг дарга хорооны зохион байгуулагч нар байршил тэмдэглэгдээгүй өрхийн байршлыг байрлаж буй байршил дээр нь цэглэх байдлаар тэмдэглэх бөгөөд энэ мэдээлэл ХАӨМС-ийн санд уртраг, өргөрөг (decimal degree) байдлаар хадгалагдах бөгөөд тухайн өрх нүүсэн, шилжсэн тохиолдолд өрхийн байршлыг мөн адил шинээр тэмдэглэх ёстой юм. Ингэснээр нийт өрхийн байршил байнгын цаг хугацааны (realtime) зөв байршилтай байх боломж бүрдэж байгаа юм.

ҮСХ-ны зүгээс тооллогын товын өмнөх 2 сарын турш 7 хоногт 1 удаа өрхийн байршил тэмдэглэгдсэн эсэх, өрхийн байрлаж буй засаг захиргааны харьяа нутаг дэвсгэрт тэмдэглэсэн эсэх зэргийг улсын хэмжээнд өрх бүрээр шалган аймаг, дүүргээр гарган хүргүүлж хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн өрхийн байршил тэмдэглэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор нийслэлийн байршил тодорхойлоогүй өрх ихтэй хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарыг дүүрэг бүрээр хуваарийн дагуу ҮСХ дээр нэгдсэн байдлаар ажиллуулсан.

Цаашид анхаарах асуудал, хүндрэл бэрхшээл: Энэ удаагийн завсрын тооллогын үзэл баримтлалын дагуу бүртгэлд суурилсан зарчмыг баримтлах үүднээс төв суурин газрын өрхийн байршлыг кадастрын мэдээллийн сантай тулган хаягийг тодорхойлох шаардлага үүссэн. Гэвч хаягийг тулган тодорхойлох ажилд дараах бэрхшээл хүндрэлүүд тулгарч байлаа. Үүнд:

- Олон эх сурвалжаас авсан хаягийн мэдээлэл нь стандарт, бүтцийн хувьд зөрүүтэй байх
- ГХГЗЗГ-аас авсан кадастрын мэдээлэл дутуу (10 аймгийн мэдээлэл авсан, 11 аймгийн мэдээлэл аваагүй болон шаардлага хангаагүй)
- Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраас авсан гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүс доторх өрхүүдийн байршлыг тогтоох
- Хаягийн нэгдсэн сан, стандарт байхгүйн улмаас ХАӨМС, кадастрын сан, орон сууцны сангууд дахь хаягийн үзүүлэлт, бичиглэл, стандарт зөрүүтэй байх

ХАӨМС програмд онлайн газрын зураг ашиглан өрхийн байршил тэмдэглэх үед олон хэрэглэгч зэрэг хандах үед програм гацах, зарим баг хорооны ХАӨМС-д бүртгэл хийж буй хүний чадвараас хамаарч өрхийн байршил тэмдэглэж чадахгүй байх, алдаатай буруу тэмдэглэх зэрэг хүндрэл тулгарч байлаа.

ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын мэдээллийг боловсруулахад Тооллогын товчооны ажилчид ажилласан бөгөөд сүүлийн үеийн статистик шинжилгээний багц програм болох SPSS-ыг ашиглав.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2015 ОНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

1	<i>Хүн амын бүртгэл</i>	Тухайн газар нутагт тодорхой цаг хугацааны дотор гарсан хүн ам зүйн үзэгдэл болон хүн амыг бүртгэж авах үйл явц болно.
2	<i>Хүн амын тоо</i>	Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.
3	<i>Суурин хүн ам</i>	Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг хэлнэ.
4	<i>Нас</i>	Төрсөн өдрөөс эхлэн (он, сар, өдөр) бүтэн жилүүдээр тооцсон хугацаа буюу төрсөн сар, жилийн асуултын хариултад суурилсан тооцоогоор илэрхийлсэн хугацааг нас гэнэ.
5	<i>Өрх</i>	Ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан, зарим гишүүд нь огт хамааралгүй, эсвэл эдгээрийн аль алианаас бүрдсэн байж болно. Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.
6	<i>Хүн амын байршил</i>	<p>Хүн ам, орон сууцны 2000, 2010 оны улсын тооллогод “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” Монгол Улсын хуулинд зааснаар:</p> <p>Хот гэдэгт “15000–аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн” гэсэн заалт;</p> <p>Тосгон гэдэгт “500-15000 хүртэл оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн өөрийн удирдлага бүхий суурин газар мөн” гэсэн заалтыг тус тус баримталсан.</p>
7	<i>Орон сууцны байшин</i>	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна.
8	<i>Бие даасан тохилог сууц</i>	Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.

9 *Сууцны тусдаа байшин*

Гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын усан систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.

10 *Нийтийн байр*

Бүх шатны сургуулиудын оюутан, сурагчдын хамтран амьдрахад зориулагдсан байр, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид нийтээр амьдрахад зориулсан байр, амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, шорон, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байр.

11 *Сууцны талбай (кв.метр)*

Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай /амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын болон хооллох өрөө/ туслах өрөө, тасалгаа /гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах/-ны талбайн нийлбэр

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ,
НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

ХҮН АМЫН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Монгол Улсын харьяат хүн амын тоо 2015 оны жилийн эцсийн байдлаар 3057.8 мянга байв. Харьяат хүн амаас гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд 87.4 мянга байна. Мөн тус улсын нутаг дэвсгэрт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат, харьяалалгүй 19.8 мянган хүн оршин сууж байна.

ЗУРАГ 2.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, 2015 ОН



Монгол Улсын хүн амын 49.2 хувь нь эрэгтэйчүүд, 50.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 97 болов. 2010 оны тооллогоор суурин хүн амын тоо 2647.5 мянга байсан бөгөөд 2010-2015 оны хоорондох 5 жилийн хугацаанд Монгол Улсын суурин хүн ам 342.7 мянган хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 2.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР


Он	Хүн амын тоо			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1918	647.5	330.2	317.3	104.1
1935	738.2	370.8	367.4	100.9
1944	759.1	371.3	387.8	95.7
1956	845.5	420.3	425.2	98.8
1963	1 017.1	508.0	509.1	99.8
1969	1 197.6	597.4	600.2	99.5
1979	1 595.0	798.9	796.1	100.4
1989	2 044.0	1 020.7	1 023.3	99.7
2000	2 373.5	1 178.0	1 195.5	98.5
2010	2 754.7	1 363.9	1 390.8	98.1
2015	3 057.8	1 503.6	1 554.2	96.7

Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) 2010 онд 98.1 байсан бол 2015 онд өмнөх тооллогын түвшингээс 1.4 пунктээр буурсан байна. Хүйсийн харьцаа 1979 оноос хойш бага зэрэг буурч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаатай холбоотой юм.

ХҮН АМЫН ӨСӨЛТ

Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. Хүн ам 1950-иад оны дунд үе хүртэл жилд дунджаар 0.9 хувиас багаар өсч байснаа 1956 оноос огцом нэмэгдэж, 1989 он хүртэл жилд дунджаар 2.5 хувиас илүүгээр өссөн байна (зураг 2.2). 1918-1935, 1935-1944 оны тооллого хоорондын хүн амын өсөлт бага байгаа нь 1930-аад оны их хэлмэгдүүлэлт, 1939 оны Халх голын дайн ба дэлхийн 2 дугаар дайн зэрэг нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас гадна хүн амын дунд тархсан өвчлөл их байснаас нас баралт өндөр, төрөлт бага байсантай холбоотой. 1956-1989 оны хооронд хүн ам жилд дунджаар 2.5-2.9 хувь тогтвортой өсч иржээ. Энэ нь ард түмний аж амьдрал, үүний дотор хүн амын эрүүл мэндийн түвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээгээр нас баралт буурч, гадаад шилжих хөдөлгөөн бараг байхгүй байсантай холбоотой. Харин 1989-2000 оны тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт 1.4 хувь болсон нь өмнөх 10 жилийнхээс 1.1 пунктээр буурчээ. Энэ хугацаанд хүн амын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь гадаад шилжих хөдөлгөөн байлаа. 1989-1990 онд Монгол Улсад ажиллаж, амьдарч байсан хуучин Зөвлөлт Холбоот Улсын 50 шахам мянган иргэн нутаг буцаж, 1990-ээд оны дундуур 50 гаруй мянган казах иргэд Казахстан улсад хөдөлмөрийн гэрээтэй ажиллахаар явж, шилжин суурьшсаны зэрэгцээ манай улсын олон мянган залуучууд гадаадад хөдөлмөр эрхэлж, суралцах болсноос шалтгаалсан юм.


ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН 1918-2015 ОНЫ ТООЛЛОГО ХООРОНДЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ТООЛЛОГЫН ОНУУДААР



Харин 2010 оноос 2015 он хүртэлх тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт өмнөх тооллогын дүнгээс 0.7 пунктээр нэмэгдсэн нь хүн амын тоонд эзлэх идэр насны хүн ам их, түүнчлэн, төрөх насны эмэгтэйчүүдийн тоо их байгаа нь хүн амын өсөлтөд ихээхэн нөлөөлсөн байна.

Сүүлийн 10 гаруй жилийн хүн амын цэвэр өсөлт нь Монгол Улсын хүн амын өсөлтөд нөлөө үзүүлсэн юм. Төрөлтийн ерөнхий коэффициент 1990 оноос хойш эрчимтэй буурах хандлага ажиглагдаж байсан хэдий ч 2006 оноос хойш өсч, 2010 онд 23.1 болж суурьшин, 2011 оноос дахин өсч, 2014 онд 28.0 болсноо 2015 онд 27.1 болж өмнөх оныхоос 0.9 пунктээр буурчээ. Нас баралтын ерөнхий коэффициент 2006 оноос тогтмол бага зэргээр буурч 2015 онд 5.8 болж, 0.7 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 2.3. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ 1000 ХҮНД НОГДОХООР, 2006-2015 ОНУУДААР



Тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойших аймаг, нийслэлийн хүн амын өсөлт эрс тэс ялгаатай болсон нь доорх хүснэгтээс харагдаж байна. Энэ нь гагцхүү шилжих хөдөлгөөнтэй холбоотой гэж үзэж болно. 2000-2010 онд нийслэл, 5 аймгийн хүн амын тоо өсч, бусад бүх аймгийн хүн амын тоо буурч байсан. Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас өндөр байгаа нь нийслэл, суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой. Сүүлийн хоёр тооллого хоорондын аймгуудын хүн амын тоо нэмэгдсэн байгаа нь улсын хэмжээнд төрөлтийн түвшин нэмэгдсэнээс ихээхэн шалтгаалсан нь тооллогын үр дүнгээс харагдаж байна.

ХҮСНЭГТ 2.2. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР 1989-2015 ОН

Аймаг, нийслэл	2000/1989 (%)	2010/2000 (%)	2010/2015 (%)	Жилийн дундаж өсөлт (%)		
				1989-2000	2000-2010	2010-2015
БҮГД	116.1	116.1	111.0	1.37	1.46	2.20
Архангай	114.9	87.1	108.8	1.27	-1.17	1.77
Баян-Өлгий	100.2	96.7	113.8	0.02	-0.30	2.76
Баянхонгор	113.7	89.7	110.3	1.17	-0.93	2.06
Булган	119.0	86.9	111.9	1.59	-1.20	2.37
Говь-Алтай	101.4	84.2	104.9	0.13	-1.44	0.98
Дорноговь	88.6	115.9	111.4	-1.10	1.44	2.27
Дорнод	93.0	92.3	110.0	-0.66	-0.70	1.99
Дундговь	104.5	75.4	114.4	0.40	-2.24	2.89
Завхан	101.7	72.8	106.8	0.15	-2.48	1.35
Өвөрхангай	115.4	90.9	110.9	1.31	-0.82	2.18
Өмнөговь	110.4	130.9	100.6	0.90	2.80	0.11
Сүхбаатар	110.5	91.4	115.0	0.91	-0.78	3.00
Сэлэнгэ	114.9	97.6	108.9	1.27	-0.22	1.78
Төв	99.2	85.8	106.2	-0.07	-1.29	1.23
Увс	107.2	81.4	110.1	0.64	-1.69	2.03
Ховд	113.4	88.5	108.6	1.15	-1.04	1.73
Хөвсгөл	116.9	96.5	111.5	1.43	-0.32	2.30
Хэнтий	96.1	92.8	110.3	-0.36	-0.66	2.07
Дархан-Уул	97.1	113.6	106.7	-0.26	1.24	1.33
Улаанбаатар	138.6	163.1	112.6	3.01	5.74	2.52
Орхон	127.4	126.8	111.1	2.23	2.44	2.21
Говьсүмбэр	-	108.3	124.8	-	0.75	4.96


ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Ингэснээрээ хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг. Тухайлбал, үйлдвэр, уурхай, барилга, хөдөө аж ахуйн зэрэг салбарт ажиллах хүн хүчний нөөц хэр зэрэг байх, сургууль, эмнэлэг, үйлчилгээний байгууллагын хүчин чадал байршил ямар байх зэрэг нь хүн амын насны бүтцээс хамаарч зохицуулагддаг билээ. Нөгөө талаар хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний чиг хандлага ч насны бүтцээс хамааралтай байдаг.

Тухайлбал, хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болоход (хүн амд хөдөлмөрийн насны хүний эзлэх хувь нэмэгдэх үйл явц) цаашид хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүний онцлогийг харгалзан ямар төрлийн ажлын байрыг илүү хэрэгцээтэй болохыг тохируулах шаардлага гардаг.

ЗУРАГ 2.4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ТООЛЛОГЫН ОНУУДААР



Нийт хүн амын тоонд насны бүлэг тус бүрийн хүн амын эзлэх хувийн жин 2015 онд 2010 оныхоос зарим насанд өөрчлөгдөв. Тухайлбал, 0-4 насанд бага зэрэг өссөн нь 2010-2014 онуудад төрөлт нэмэгдсэнтэй холбоотой. Монгол Улсын түүхэнд нийт хүн амд эзлэх 15-64 насны хөдөлмөрийн насны хүн амын хувь хамгийн өндөр байгаа он жилүүд ирсэн байна. Энэ үед төрөөс ажиллах хүчийг дэмжсэн, төрөлтийн түвшинг нэмэгдүүлэх төрийн бодлого боловсруулах нь Монгол Улсын цаашдын хүн ам зүйн бодлогод чухал үүрэгтэй юм.


ХҮСНЭГТ 2.3. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2015 ОН

Насны бүлэг	2010		2015		Хүйсийн харьцаа ¹	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2015
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	98.1	96.7
0-4	10.9	10.4	13.2	12.1	103.2	105.0
5-9	8.2	7.7	10.1	9.4	103.8	104.2
10-14	8.9	8.5	7.4	6.9	102.8	103.7
15-19	9.9	9.5	8.1	7.6	102.4	103.1
20-24	11.6	11.1	9.0	8.5	101.7	101.7
25-29	9.9	9.6	10.4	10.1	100.4	100.3
30-34	8.8	8.6	8.7	8.6	99.6	98.2
35-39	7.8	7.8	7.6	7.6	97.7	96.9
40-44	6.7	6.9	6.7	6.9	95.9	93.6
45-49	5.8	6.0	5.6	6.0	94.4	90.2
50-54	4.3	4.7	4.7	5.2	90.1	87.4
55-59	2.5	2.8	3.4	4.1	86.2	81.0
60-64	1.6	2.0	1.9	2.4	80.7	76.8
65-69	1.3	1.5	1.2	1.6	82.2	70.3
70+	1.9	2.7	1.9	2.8	66.8	63.5

Хүн амын хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь зүй ёсны үзэгдэл бөгөөд тооллогын мэдээллийн чанар сайн байгааг харуулж байна. Монгол Улсад төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа сүүлчийн 5 жилд 103-105 байсан нь тооллогын дүнгээс харагдаж байна. Манай улсын нийт хүн амд 25-29 насныхны эзлэх хувь өндөр байгаа нь 1980-аад онд төрөлт өндөр байсныг гэрчилнэ.

Нас, хүйсийн бүтцийг харуулах өөр нэг гол үзүүлэлт бол хүн амын нас, хүйсийн суварга билээ.

ЗУРАГ 2.5. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН СУВАРГА, 2010, 2015 ОН



Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэршиж байгааг харуулж байна. Харин 10-19 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин эрс буурч байсныг харуулж байна. Түүнчлэн, 0-4 нас болон 5-9 насанд суваргын суурь ихээхэн өргөн болсон нь сүүлийн жилүүдийн төрөлтийн түвшин ихээхэн нэмэгдсэнийг илэрхийлж байна. Манай улс хүн амын хүйсийн харьцаа харьцангуй жигд байдаг улс юм. Тухайлбал, 100 эмэгтэйд 99-103 эрэгтэй ногддог нь насны бүлгээс хамааран янз бүр байдаг. Түүнчлэн, аймаг, нийслэлийн түвшинд тус үзүүлэлт мөн ойролцоо жигд байна.

ХҮСНЭГТ 2.4. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2015 ОН

Аймаг, нийслэл	2010 он			2015			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2015
БҮГД	2 754 685	1 363 923	1 390 762	3 057 778	1 503 612	1 554 166	98.1	96.7
Архангай	84 584	42 219	42 365	92 059	46 136	45 923	99.7	100.5
Баян-Өлгий	88 056	44 127	43 929	100 189	50 026	50 163	100.5	99.7
Баянхонгор	76 085	38 237	37 848	83 936	41 508	42 428	101.0	97.8
Булган	53 655	27 623	26 032	60 014	30 512	29 502	106.1	103.4
Говь-Алтай	53 590	26 830	26 760	56 209	27 973	28 236	100.3	99.1
Дорноговь	58 612	29 537	29 075	65 267	32 669	32 598	101.6	100.2
Дорнод	69 552	35 134	34 418	76 476	38 420	38 056	102.1	101.0
Дундговь	38 821	19 727	19 094	44 429	22 379	22 050	103.3	101.5
Завхан	65 481	32 916	32 565	69 916	34 936	34 980	101.1	99.9
Өвөрхангай	101 314	50 879	50 435	112 353	56 043	56 310	100.9	99.5
Өмнөговь	61 314	35 137	26 177	61 655	30 918	30 737	134.2	100.6
Сүхбаатар	51 334	26 165	25 169	59 034	29 815	29 219	104.0	102.0
Сэлэнгэ	97 584	49 625	47 959	106 292	53 941	52 351	103.5	103.0
Төв	85 166	44 394	40 772	90 421	46 567	43 854	108.9	106.2
Увс	73 328	37 049	36 279	80 763	40 637	40 126	102.1	101.3
Ховд	76 870	38 366	38 504	83 517	41 725	41 792	99.6	99.8
Хөвсгөл	114 926	57 193	57 733	128 159	63 653	64 506	99.1	98.7
Хэнтий	65 811	33 633	32 178	72 609	36 697	35 912	104.5	102.2
Дархан-Уул	94 625	46 491	48 134	100 939	49 618	51 321	96.6	96.7
Улаанбаатар	1 240 037	597 337	642 700	1 396 288	671 764	724 524	92.9	92.7
Орхон	90 700	44 488	46 212	100 731	49 405	51 326	96.3	96.3
Говьсүмбэр	13 240	6 816	6 424	16 522	8 270	8 252	106.1	100.2

Тооллого хоорондын хүн амын тоо бүх аймаг, нийслэлд нэмэгдсэн байгаа нь мөн хүн амын төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой юм. Хот, хөдөөд хүн амын хүйсийн харьцаа ялгаатай байна. Хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа улсын дунджаас харьцангуй өндөр байхад хотын хүн амынх улсын дунджаас бага байна. Энэ нь нийслэлд шилжин ирж байгаа хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байгаагаас шалтгаалсан байх талтай.

ХҮСНЭГТ 2.5. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2015 ОН

Байршил	2010 он			2015 он		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
БҮГД	1 363 923	1 390 762	98.1	1 503 612	1 554 166	96.7
Хот	922 944	982 343	94.0	1 014 808	1 081 372	93.8
Хөдөө	440 979	408 419	108.0	488 804	472 794	103.4

Монгол Улсын хүн ам зүйн ачаалал 2015 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 51 хүн ногдож байна. Амьдрал дээр энэ үзүүлэлт тооцооноос нэлээд илүү байдаг. Тухайлбал, хөдөлмөрийн насанд байгаа үедээ 15-24 насныхан ихэнх нь боловсролоо ахиулах, мэргэжил эзэмшихээр суралцдаг учраас тэжээлгэгч байдаг. Мөн хөдөлмөрийн насанд байгаа боловч жирэмсэн, бага насны хүүхэд болон өндөр настанг асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй, ажиллах чадваргүй эсвэл ажилгүйчүүд гэх мэт тэжээлгэгчдийн тоо өсдөг.

ХҮСНЭГТ 2.6. ХҮН АМЫН ТОО, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2015

Аймаг, нийслэл	Хүн амын тоо	Хүн ам зүйн ачаалал	Үүнээс:		Хөгшрөлтийн индекс	Хүйсийн харьцаа
			Хүүхэд	Хөгшид		
БҮГД	3 057 778	51.3	45.5	5.8	12.8	96.7
Баруун бүс	390 594	56.8	51.2	5.6	10.9	100.0
Баян-Өлгий	100 189	62.3	57.1	5.2	9.1	99.7
Говь-Алтай	56 209	51.6	45.9	5.7	12.5	99.1
Завхан	69 916	52.5	45.8	6.6	14.5	99.9
Увс	80 763	57.7	52.4	5.2	10.0	101.3
Ховд	83 517	57.0	51.6	5.4	10.4	99.8
Хангайн бүс	577 252	50.8	44.8	6.0	13.3	99.1
Архангай	92 059	51.8	45.5	6.3	13.8	100.5
Баянхонгор	83 936	52.6	46.9	5.7	12.1	97.8
Булган	60 014	48.3	41.8	6.6	15.7	103.4
Орхон	100 731	46.8	41.4	5.4	12.9	96.3
Өвөрхангай	112 353	52.7	46.1	6.6	14.3	99.5
Хөвсгөл	128 159	51.8	46.1	5.6	12.2	98.7
Төвийн бүс	485 525	50.7	44.5	6.2	13.8	101.3
Говьсүмбэр	16 522	55.1	49.8	5.3	10.6	100.2
Дархан-Уул	100 939	49.2	42.9	6.3	14.7	96.7
Дорноговь	65 267	52.8	47.8	5.0	10.6	100.2
Дундговь	44 429	51.7	43.9	7.7	17.6	101.5
Өмнөговь	61 655	52.1	46.2	5.8	12.6	100.6
Сэлэнгэ	106 292	48.7	43.2	5.6	12.9	103.0
Төв	90 421	50.9	43.8	7.1	16.2	106.2
Зүүн бүс	208 119	50.6	45.0	5.7	12.6	101.7
Дорнод	76 476	50.2	44.6	5.6	12.4	101.0
Сүхбаатар	59 034	49.6	44.3	5.2	11.8	102.0
Хэнтий	72 609	52.0	45.9	6.1	13.3	102.2
Улаанбаатар	1 396 288	50.4	44.6	5.7	12.8	92.7

Манай улсын хүн амын төрөлтийн түвшин 1970-1989 онд өндөр байснаас шалтгаалан хүн ам зүйн ачаалал, тэр дундаа хүүхдийн ачаалал өндөр байжээ. Тэгвэл 2015 онд хөдөлмөрийн насны хүн ам ихэнх хувийг эзэлж байгаа учир хүн ам зүйн ачаалал буурсан байна. Түүнчлэн, баруун аймгуудын хүн ам зүйн ачаалал улсын дунджаас нилээд их байна. Энэ нь тухайн аймгуудын төрөлтийн түвшин өндөр, хөдөлмөрийн насныханд ачаалах хүүхдийн тоо их байгааг илэрхийлж байна. Харин зүүн аймгуудын ачаалал улсын дунджаас бага байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын хүн амын тоо 2010-2015 оны хооронд жилд дунджаар 2.2 хувиар өссөн нь өмнөх тооллого хоорондохоос 0.7 пунктээр илүү юм. Энэ нь сүүлийн жилүүдийн төрөлтийн тоо эрс нэмэгдсэнтэй холбоотой. Ялангуяа 2013-2015 онуудад жилд дунджаар 81 583 хүүхэд төрж байв.

Улс орнууд дахь хүн амын дунд насны тодорхой бүлгүүдийн өсөлт, насжилт нэмэгдэж буурах хандлагуудыг тодорхойлон харуулахад хүн ам зүйн суварга нэн тохиромжтой байдаг. Манай улсын хүн ам зүйн суваргаас харахад идэрших хандлагатай залуу насны хүн ам дийлэнх хувийг эзэлж байна.

Үүнээс үзэхэд хүн амын тоонд 15-64 насны хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин өндөр байгаа энэ он жилүүдэд ажиллах хүчин, хөдөлмөрийн насны хүн амыг дэмжих бодлого зайлшгүй шаардлагатай байна.

Сүүлийн 3-аас 4 жилийн Монгол Улсын төрөлтийн түвшин нэмэгдсэн нь хүн амын өсөлт, хөгжлийг нэмэгдүүлэх, хүн амын насны бүтцийг залуужуулах эерэг сайн нөлөөтэй.

Гэвч эдгээр хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол эзэмших, бүрэн дунд боловсрол эзэмших, дээд боловсрол эзэмших, ажиллах хүчинд орох гэх мэт шат дараатайгаар нийгэмд ачаалал үүсгэдэг. Тиймээс эртнээс энэ бүлгийн хүн амд зориулсан тусгайлсан бодлого явуулж ажиллах нь зүйтэй.

Аймаг, нийслэлийн хүн амын тоо мөн жигд өссөн байгаа нь өндөр төрөлтийн түвшинтэй холбоотой. Түүнчлэн, аймгуудын хүн амын тоонд хүн амын шилжих хөдөлгөөн тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа болно.

Баруун аймгуудын хүн амын тоо бусад аймгуудыг бодвол буурч байна. Тухайлбал, Завхан аймгийн нийт сумын 60 орчим хувь нь 2000 хүрэхгүй хүн амтай байна. Энэ нь нийслэл, төв суурин газар бараадсан шилжих хөдөлгөөний нөлөөлөл байх магадлалтай юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УЛСЫН ХАРЬАЛАЛ,
ҮНДЭС УГСАА

ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа суурин хүн амын 99.3 хувь нь Монгол Улсын харьяат, 0.7 хувь нь гадаадын харьяат иргэн байна. Аль нэг улсын харьяалалгүй хүн 16 байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛААР, 2015 ОН



Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэдийн тоо 2010 оныхоос 21.8 хувь буюу 3 551 хүнээр өсчээ. Харин харьяалалгүй иргэдийн тоо 2010 оныхоос 92 хүнээр буурсан дүн гарав.

Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын харьяат иргэдийн 72.5 хувь нь нийслэлд, 6.2 хувь нь Баян-Өлгий, 5.3 хувь нь Дорнод, 4.1 хувь нь Өмнөговь аймагуудад амьдарч байна.

Нийслэлд оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн эзлэх хувийн жин 2010 оныхоос 15.8 пунктээр өсч, 72.5 хувьтай болсон байна. Өмнөх тооллогоор Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын харьяат иргэдийн 24.0 хувь нь Өмнөговь аймагт амьдарч байсан бол 2015 онд 4.1 хувь болж 19.9 пунктээр буурсан байна.

Харин Баян-Өлгий аймагт 2010 оныхоос 5.8 пунктээр өсч 6.2 хувь, Дорнод аймагт 3.6 пунктээр өсч 5.3 хувь болсон нь бусад аймгуудаас өндөр өсөлттэй байна.



ХҮСНЭГТ 3.1. МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬАТ ИРГЭДИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010, 2015 ОН

Аймаг, нийслэл	2010		2015	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	16 320	100.0	19 871	100.0
Архангай	21	0.1	33	0.2
Баян-Өлгий	71	0.4	1 233	6.2
Баянхонгор	43	0.3	10	0.1
Булган	42	0.3	29	0.1
Говь-Алтай	8	0.0	21	0.1
Дорноговь	319	1.9	175	0.9
Дорнод	284	1.7	1 062	5.3
Дундговь	28	0.2	26	0.1
Завхан	45	0.3	36	0.2
Өвөрхангай	21	0.1	19	0.1
Өмнөговь	3 913	24.0	806	4.1
Сүхбаатар	156	1.0	160	0.8
Сэлэнгэ	323	2.0	142	0.7
Төв	183	1.1	146	0.7
Увс	32	0.2	22	0.1
Ховд	191	1.2	238	1.2
Хөвсгөл	41	0.2	56	0.3
Хэнтий	240	1.5	123	0.6
Дархан-Уул	255	1.6	327	1.6
Улаанбаатар	9 254	56.7	14 402	72.5
Орхон	807	4.9	778	3.9
Говьсүмбэр	43	0.3	27	0.1


Гадаадын харьяат иргэдийн насны бүтцийг Монгол Улсын хүн амын насны бүтэцтэй харьцуулахад ялгаатай байна. Монгол Улсад амьдарч байгаа гадаадын харьяат 3 хүн тутмын хоёр нь 25-54 насныхан байна. Энэ нь гадаадын харьяат иргэдийн дийлэнх нь хөдөлмөрийн насны хүн ам байгааг харуулна.

ХҮСНЭГТ 3.2. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2015 ОН

Насны бүлэг	Суурин хүн амын насны бүтэц	Гадаадын харьяат иргэд			
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
БҮГД	2 990 242	19 871	13 277	6 594	201.3
0-14	899 045	3 175	1 586	1 589	99.8
15-24	493 766	1 761	980	781	125.5
25-34	551 495	4 219	3 015	1 204	250.4
35-44	425 552	4 262	3 138	1 124	279.2
45-54	325 413	3 853	2 858	995	287.2
55+	294 971	2 601	1 700	901	188.7

Гадаадын харьяат иргэдийн дунд 0-14 насны хүн амын эзлэх хувь 2010 оныхоос 2 дахин өссөн байна. Онцлох нэг зүйл нь гадаадын харьяат иргэдийн хүйсийн харьцаа Монгол Улсын харьяат иргэдийнхээс эрс ялгаатай, гол төлөв эрэгтэйчүүд ирж суурьшдаг байна.

ЗУРАГ 3.2. ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН НАСНЫ БҮТЭЦ, ХУВИАР, 2010, 2015 ОН



Мөн гадаадын харьяат иргэдийн дунд 55-аас дээш насны хүн амын эзлэх хувь 2010 оныхоос 3.4 пунктээр өссөн бол 35-44 насны хүн ам 2010 оныхоос 6.9 пунктээр, 15-24 насны хүн ам 3.4 пунктээр буурчээ.



ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогоор Монгол Улсын харьяат суурин хүн амын 84.5 хувийг халхчууд эзэлж, өмнөх тооллогоос 2.1 пунктээр өссөн байна. Казахуудын нийт хүн амд эзлэх хувийн жин 3.9 хувь байгаа нь халхчуудын дараа орж байна. Харин Буриад, Баяд, Захчин, Өөлд угсаатнууд 2010 оныхоос ихээр буурсан байна.

ХҮСНЭГТ 3.3. МОНГОЛ УЛСАД СУУГАА МОНГОЛЫН ХАРЬААТ ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010, 2015 ОН

Үндэс угсаа	2010		2015	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	2 631 117	100.0	2 970 355	100.0
Халх	2 168 141	82.4	2 510 821	84.5
Казах	101 526	3.9	114 506	3.9
Дөрвөд	72 403	2.8	70 970	2.4
Баяд	56 573	2.2	50 843	1.7
Буриад	45 087	1.7	37 867	1.3
Захчин	32 845	1.2	30 110	1.0
Дарьганга	27 412	1.0	26 834	0.9
Урианхай	26 654	1.0	24 881	0.8
Дархад	21 558	0.8	22 579	0.8
Хотогойд	15 460	0.6	21 443	0.7
Торгууд	14 176	0.5	14 287	0.5
Өөлд	15 520	0.6	12 787	0.4
Хотон	11 304	0.4	11 580	0.4
Мянгад	6 592	0.3	5 993	0.2
Тува	5 169	0.2	4 038	0.1
Барга	2 989	0.1	2 605	0.1
Сартуул	1 286	0.0	2 166	0.1
Үзэмчин	2 577	0.1	2 060	0.1
Цаатан	282	0.0	541	0.0
Хамниган	537	0.0	412	0.0
Харчин	152	0.0	332	0.0
Элжигэн	1 340	0.1	315	0.0
Узбек (Чантуу)	260	0.0	203	0.0
Монголын харьяат бусад	733	0.0	1 401	0.0
Монголын харьяат гадаад	541	0.0	781	0.0

Хотон, казахуудын дунд 0-14 настай хүүхдийн эзлэх хувийн жин тус бүр 37.4, 35.2 хувь байж, бусдаас нэлээд өндөр байгаа нь тэдний дунд төрөлт өндөр байгаатай холбоотой юм. Харин Сөнөд, Хорчин, Харчин, Элжигэн, Сартуулуудын дунд 45-аас дээш настай хүний эзлэх хувийн жин 25 хувиас илүү байгаа нь насжилтыг илэрхийлж байна.

ХҮСНЭГТ 3.4. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2015 ОН

Үндэс угсаа	Бүгд	Насны бүлэг					
		0-14	15-24	25-34	35-44	45-54	55+
БҮГД	100.0	30.2	16.6	18.4	14.2	10.8	9.8
Халх	100.0	30.0	16.1	18.7	14.4	10.9	9.9
Казах	100.0	35.2	19.4	16.9	12.0	8.6	7.8
Дөрвөд	100.0	30.2	19.4	17.1	13.5	10.7	9.2
Буриад	100.0	26.5	17.8	17.5	13.8	11.3	13.0
Баяд	100.0	30.7	19.3	16.6	13.2	10.5	9.6
Дарьганга	100.0	25.3	18.2	17.6	15.3	11.8	11.9
Урианхай	100.0	28.9	18.9	17.5	13.8	10.8	10.2
Захчин	100.0	30.6	20.4	17.0	12.8	9.7	9.5
Дархад	100.0	29.3	19.1	17.6	13.3	11.2	9.6
Торгууд	100.0	27.3	17.5	17.9	14.3	11.8	11.3
Өөлд	100.0	27.7	18.9	16.5	14.2	11.2	11.5
Хотон	100.0	37.4	20.3	15.8	11.2	8.8	6.5
Мянгад	100.0	30.9	19.7	15.8	14.1	9.9	9.6
Барга	100.0	25.6	17.8	19.3	13.9	10.1	13.2
Үзэмчин	100.0	24.8	19.1	18.9	13.1	12.0	12.2
Харчин	100.0	27.7	16.3	14.5	15.1	10.5	16.0
Хотогойд	100.0	30.1	17.1	17.0	14.9	11.2	9.8
Элжигэн	100.0	22.9	17.1	15.9	18.4	13.0	12.7
Цаатан	100.0	30.5	17.4	17.6	14.8	10.0	9.8
Сартуул	100.0	22.9	15.5	19.2	16.3	11.3	14.9
Тува	100.0	33.0	19.6	16.4	12.9	8.9	9.2
Хорчин	100.0	12.5	23.6	18.1	16.7	13.9	15.3
Узбек (Чантуу)	100.0	30.0	18.2	22.2	11.8	8.4	9.4
Халимаг	100.0	31.8	22.7	9.1	13.6	18.2	4.5
Түмэд	100.0	23.5	14.7	17.6	20.6	11.8	11.8
Сөнөд	100.0	25.0	12.5	0.0	18.8	25.0	18.8
Хамниган	100.0	24.3	20.6	16.5	14.8	9.2	14.6
Хошууд	100.0	32.7	20.7	14.4	13.2	8.4	10.5
Монголын харьяат бусад	100.0	62.0	11.4	6.4	7.3	5.9	7.0
Монголын харьяат гадаад	100.0	70.3	9.6	6.7	6.0	3.6	3.8

Байршлын хувьд Халхчууд бүх аймаг, нийслэлд оршин сууж байгаагийн дотор нийт хүн амд эзлэх хувиар Ховд (28.4 хувь), Увс (13.8 хувь), Баян-Өлгий (1.2 хувь) зэрэг аймагт хамгийн бага хувийг эзэлж байна. Харин Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өмнөговь аймгийн нийт хүн амын 99-өөс дээш хувь нь халхчууд байна. Олон угсаатны өлгий нутаг Ховд аймгийн нийт хүн амын дотор Халх 28.4 хувь, Захчин 24.7 хувь, Казах 12.2 хувь, Урианхай 7.8 хувь, Торгууд 7.3 хувь, Дөрвөд 6.4 хувь, Өөлд 6.3 хувь, Мянгадууд 4.9 хувь байгаа нь бусад аймгаас онцлог юм.

Бүс нутгаар үзэхэд Баруун бүсийн нийт хүн амын дотор Халх 41.6 хувь, Казах 25.1 хувь, Дөрвөд 10.6 хувь, Баяд 7.2 хувь, Захчин 5.4 хувийг эзэлж байна. Казахчуудын 75.5 хувь нь Баян-Өлгий аймагт, Дөрвөдүүдийн 48.6 хувь, Захчингуудын 54.3 хувь, Хотончуудын 49.9 хувь нь Увс аймагт оршин сууж байна.


Хангайн бүсийн нийт хүн амын дотор Халх 89.6 хувь, Дархад 3.5 хувь, Хотогойд 3.4 хувийг эзэлж байгаа бөгөөд Хотогойдуудын 89.6 хувь, Дархадчуудын 85.4 хувь нь Хөвсгөл аймагт оршин сууж байна.

Зүүн бүсийн нийт хүн амын дотор Халх 75.3 хувь, Дарьганга 11 хувь, Буриад 9.9 хувь, Барга 1 хувийг эзэлж байна. Дарьгангачуудын 81.2 хувь, Үзэмчингүүдийн 7.9 хувь нь Сүхбаатар аймагт оршин сууж байна. Мөн Дорнод аймгийн нийт хүн амын 2.6 хувь нь Барга, 2.2 хувь нь Үзэмчингүүд байгаа нь эдгээр угсаатны хамгийн олноороо оршин суудаг аймаг бөгөөд тухайн угсаатны бүлгийн 74.1 ба 79.9 хувийг тус тус төлөөлж байна.

Төвийн бүсийн нийт хүн амын дотор Халх 92.8 хувь, Баяд 1.5 хувь, Дөрвөд 1.4 хувийг эзэлж байна.


Монгол Улсын суурин хүн амын 84.5 хувь Халхчууд бөгөөд бүх аймаг, нийслэлд тархан суурьшсан байдаг. Нийт хүн амд эзлэх хувийн жингээр хамгийн их угсаатны бүлэгт Халх, Казах, Дөрвөд, Баяд, Буриадчууд орж байна.

ЗУРАГ 3.3.1. КАЗАХ УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМГААР, 2015 ОН




Казахчууд Баян-Өлгий, Ховд, Сэлэнгэ, Төв аймгуудад болон Улаанбаатар хотод ихээхэн оршин сууж байгааг Зураг 3.3.1-ээс харагдаж байна.

ЗУРАГ 3.3.2. ДӨРВӨД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМГААР, 2015 ОН




Дөрвөдчүүдийн 48.6 хувь нь Увс аймагт, 28.3 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байгаа бөгөөд бүх аймагт тархан суурьшсан байна.

ЗУРАГ 3.3.3. БАЯД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМГААР, 2015 ОН



Баядуудын 54.3 хувь нь Увс аймаг, 25.4 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байгаагаас гадна Булган, Сэлэнгэ, Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймгуудаар суурьшсан байгааг ЗУРАГ 3.3.3-аас харж болохоор байна.

ЗУРАГ 3.3.4. БУРИАД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМГААР, 2015 ОН



Буриаддуудын 41.2 хувь нь Дорнод аймаг, 32.2 хувь нь Улаанбаатар, 12.6 хувь нь Хэнтий аймагт оршин сууж байна. Мөн Буриадчууд Монгол орны хойд хэсгийн аймгууд болох Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Хэнтий, Дорнод аймгуудаар ихээхэн суурьшсан нь Зураг 3.3.4-өөс харагдаж байна.

ХҮСНЭГТ 3.5. ХҮН АМЫН ТАРХАН СУУРЬШИЛТ, ҮНДЭС УГСАА, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2015 ОН


Аймаг, нийслэл	Суурин хүн ам	Халх	Казах	Дөрвөд	Буриад	Баяд	Дарьганга	Урианхай
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Архангай	3.1	3.5	0.1	0.2	0.0	0.1	0.1	0.0
Баян-Өлгий	3.3	0.0	75.5	1.5	1.6	0.1	0.1	22.9
Баянхонгор	2.8	3.3	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
Булган	2.0	2.3	0.1	0.5	1.7	1.9	0.1	0.3
Говь-Алтай	1.9	2.2	0.1	0.1	0.1	0.0	0.1	0.1
Дорноговь	2.1	2.5	0.1	0.1	0.3	0.1	0.7	0.2
Дорнод	2.5	2.1	0.1	0.5	41.2	0.3	2.5	0.3
Дундговь	1.5	1.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Завхан	2.3	2.7	0.1	0.1	0.1	0.0	0.0	0.1
Өвөрхангай	3.8	4.4	0.1	0.0	0.4	0.0	0.0	0.0
Өмнөговь	2.0	2.4	0.1	0.1	0.4	0.1	0.1	0.1
Сүхбаатар	2.0	1.4	0.0	0.1	0.3	0.3	81.2	0.1
Сэлэнгэ	3.5	3.6	1.0	3.2	1.9	5.8	0.2	6.2
Төв	3.0	3.4	0.9	1.4	1.4	1.8	0.1	1.2
Увс	2.7	0.4	0.1	48.6	0.3	54.3	0.3	0.5
Ховд	2.8	0.9	8.8	7.4	0.2	0.3	0.2	26.1
Хөвсгөл	4.3	3.3	0.1	0.2	2.0	0.1	0.2	13.1
Хэнтий	2.4	2.6	0.5	0.4	12.6	0.3	0.7	3.2
Дархан-Уул	3.3	3.3	2.3	4.4	1.6	6.0	0.3	3.1
Улаанбаатар	44.8	49.4	9.1	28.3	32.2	25.4	12.9	19.2
Орхон	3.3	3.5	0.6	2.8	1.4	2.8	0.2	3.2
Говьсүмбэр	0.5	0.6	0.1	0.2	0.1	0.2	0.1	0.0

Аймаг, нийслэл	Захчин	Дархад	Торгууд	Өөлд	Хотон	Мянгад	Барга	Үзэмчин
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Архангай	0.0	0.1	0.2	22.2	0.1	0.0	0.0	0.1
Баян-Өлгий	0.1	0.0	0.1	0.2	0.0	0.2	0.0	0.0
Баянхонгор	0.0	0.0	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0
Булган	0.1	1.0	0.2	0.4	2.9	0.3	0.2	0.0
Говь-Алтай	0.1	0.0	0.2	0.0	0.0	0.1	0.0	0.0
Дорноговь	0.1	0.1	0.2	0.2	0.0	0.0	0.1	0.2
Дорнод	0.3	1.0	0.6	0.1	0.2	0.4	74.1	79.9
Дундговь	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Завхан	0.1	0.0	0.3	0.1	0.0	0.1	0.1	0.0
Өвөрхангай	0.0	0.0	0.2	0.1	0.0	0.0	0.0	0.0
Өмнөговь	0.1	0.1	0.3	0.1	0.1	0.1	0.0	0.1
Сүхбаатар	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.1	0.9	7.9
Сэлэнгэ	2.0	1.3	2.5	1.6	16.4	1.6	0.8	0.4
Төв	0.5	0.5	0.8	0.7	0.5	0.5	0.9	0.5
Увс	0.2	0.1	0.8	0.4	49.9	3.1	1.5	0.3
Ховд	68.0	0.2	42.1	41.0	0.4	66.0	0.6	0.1
Хөвсгөл	0.2	85.4	0.8	0.4	0.2	0.5	0.3	0.1
Хэнтий	0.1	0.1	0.3	0.1	0.0	0.1	0.7	0.1
Дархан-Уул	3.8	0.6	5.4	2.3	4.7	1.3	0.7	0.3
Улаанбаатар	22.8	7.4	43.5	28.3	9.3	23.4	18.3	9.4
Орхон	1.3	1.9	1.0	1.6	15.1	2.1	0.6	0.5
Говьсүмбэр	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.2	0.2	0.0

Аймаг, нийслэл	Харчин	Хотогойд	Элжигэн	Цаатан	Сартуул	Тува	Хорчин	Үзбек (Чантуу)
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Архангай	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0
Баян-Өлгий	1.8	0.0	0.0	0.0	0.9	34.2	0.0	4.4
Баянхонгор	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	1.4	0.0
Булган	0.3	0.1	0.0	0.7	1.9	0.1	0.0	0.0
Говь-Алтай	0.6	0.0	0.3	0.0	0.1	0.0	0.0	0.0
Дорноговь	0.3	0.1	0.0	0.0	0.0	0.1	1.4	0.0
Дорнод	4.5	0.1	0.0	0.2	3.2	0.0	5.6	0.0
Дундговь	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Завхан	0.3	1.3	0.3	0.2	0.4	0.0	0.0	0.0
Өвөрхангай	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	1.4	0.0
Өмнөговь	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.1	0.0	0.0
Сүхбаатар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Сэлэнгэ	5.4	0.4	1.9	0.6	4.0	17.6	12.5	1.5
Төв	3.6	0.3	1.9	0.9	8.1	12.1	9.7	0.5
Увс	0.0	0.1	55.9	2.4	9.0	0.2	0.0	0.0
Ховд	0.0	0.0	1.0	0.0	2.1	12.4	4.2	73.9
Хөвсгөл	11.1	89.6	5.7	90.6	3.1	0.1	4.2	0.0
Хэнтий	1.2	0.0	0.0	0.2	1.5	0.3	5.6	0.0
Дархан-Уул	2.7	0.5	0.6	0.4	3.6	12.2	0.0	3.0
Улаанбаатар	63.0	6.4	29.5	3.9	58.9	7.6	54.2	15.8
Орхон	0.6	0.8	2.5	0.0	2.5	3.0	0.0	1.0
Говьсүмбэр	4.5	0.0	0.3	0.0	0.1	0.1	0.0	0.0

Элжигэн, Хамниган, Үзэмчин, Узбек(Чантуу), Дөрвөд угсаатны бүлэг гол төлөв хөдөө суурьшиж байгааг дараах зургаас харж болно. Хөдөө суурьшиж байгаа Элжигэнчүүд 2010 оныхоос 3.8 пунктээр, Хамниган 16.5 пунктээр, Узбекчүүд 19.4 пунктээр өссөн бол Цаатан, Тува, Хотончуудын 82 дээш хувь нь Улаанбаатар хотод суурьшиж байна

ЗУРАГ 3.4. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН



ДҮГНЭЛТ

ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ

Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэдийн тоо 2010 оныхоос 21.8 хувь буюу 3 551 хүнээр өсчээ. Харин харьяалалгүй иргэдийн тоо 2010 оныхоос 92 хүнээр буурсан.

Нийслэлд оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн эзлэх хувийн жин 2010 оныхоос 15.8 пунктээр өсч 72.5 хувь болсон байна.

Баян-Өлгий аймагт оршин сууж байгаа гадаадын харьяат иргэд 2010 оныхоос 5.8 пунктээр, Дорнод аймгийнх 3.6 пунктээр өссөн нь бусад аймгуудаас их байна. Харин Өмнөговь, Хэнтий, Сэлэнгэ, Дорноговь аймагт оршин сууж байгаа гадаадын харьяат иргэд 2010 оныхоос нилээдгүй буурсан дүнтэй байна.

Мөн гадаадын харьяат иргэдийн дунд 0-14 насны хүн амын эзлэх хувь 2010 оныхоос 2 дахин өссөн бол 15-24, 35-44 насныхны эзлэх хувь бууралттай байна.

ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА

Монгол Улсын суурин хүн амын 84.5 хувийг Халх үндэстэн, 3.9 хувийг Казах, 2.4 хувийг Дөрвөд, 1.7 хувийг Баяд, 1.3 хувийг Буриад ястан эзэлж байгаа нь улсын нийт хүн амын 94 орчим хувь болж байна.

Байршлын хувьд Халхчууд бүх аймаг, нийслэлд оршин сууж байгаагийн дотор нийт хүн амд хамгийн бага хувиар Ховд 28.4 хувь, Увс 13.8 хувь, Баян-Өлгий 1.2 хувийг эзэлж байгаа бол Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өмнөговь аймгуудын нийт хүн амын 99-с дээш хувь нь Халхчууд байна.

Өмнөх тооллогоор Цаатан, Тува, Казах, Дархадуудын ихэнх нь хөдөө орон нутагт суурьшиж байсан бол 2015 оны тооллогоор ихэнх нь хотод суурьшсан байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМЫН СУУРШИЛ, НЯГТРАЛ

ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газарзүйн янз бүрийн бүсэд оршдог, байгалийн баялаг улс орны нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газарзүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран аймаг, нийслэлийн хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн төвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ. Хүн амын суурьшлыг хот, хөдөө, бүс нутгаар тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, бүс нутгийн болон орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болно.

Хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 45 хувь нь Улаанбаатар хот, 19.2 хувь нь Хангайн бүс, 16 хувь нь Төвийн бүс, 12.9 хувь нь Баруун бүс, 6.9 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна. Нийт хүн амд эзлэх Улаанбаатар хотын хүн амын суурьшил 2010 оныхоос 1.4 пунктээр өссөн бол бусад бүс нутгуудад буурсан байна.

Төв суурин газар руу 1990-ээд оны эхэн үеэс чиглэсэн шилжилт сүүлийн 10 гаруй жилд үргэлжилсэн хэвээр байна. Тухайлбал, 2010 онд манай улсын 100 хүн тутмын 43 хүн нь нийслэлд амьдарч байсан бол 2015 онд 45 болж нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4.1. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010, 2015 ОН

Бүс	Хүн ам (мян.хүн)		2015 2010 %	Дүнд эзлэх хувь	
	2010	2015		2010	2015
БҮГД	2 647.5	2 990.2	12.9	100.0	100.0
Баруун	352.5	387.0	9.8	13.3	12.9
Хангай	514.7	573.1	11.3	19.4	19.2
Төв	440.7	477.2	8.3	16.6	16.0
Зүүн	185.3	207.5	12.0	7.0	6.9
Улаанбаатар	1 154.3	1 345.5	16.6	43.6	45.0

Ерөнхийдөө хүн амын шилжилт хөдөлгөөн Улаанбаатар руу чиглэж байгаа нь олон баримтаас харагдана. Бүс нутгаар хүн амын өсөлтийн хувийг үзэхэд улсын түвшингээс бага байна. Дийлэнх аймгийн хүн амын тоо буурч, улсын дүнд эзлэх хувийн жин багасахад Улаанбаатар хотын өсөлт их байгааг дараах хүснэгтээс харагдаж байна (Хүснэгт 4.2.).

Өмнөговь аймгийн нийт хүн ам нь 2010 оноос хойш хамгийн бага 0.8 хувиар өссөн байна. Харин Говьсүмбэр 24.5, Сүхбаатар 15.1, Баян-Өлгий 14.8, Дундговь аймагт 14.5 хувиар өсч бусад аймгуудаас өсөлтийн хувь нь их байна.


Монгол Улсад сүүлийн 30 гаруй жилд хотжих үйл явц улам бүр нэмэгдсээр байна. 2000 оноос хойш хөдөө аж ахуйд тохиолдсон ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдэл малчдад хүндээр тусч, нийслэл болон бусад томоохон хот, суурин газар руу шилжих хөдөлгөөн нэмэгдсэн нь 2010, 2015 оны тооллогын дүнгээс харагдаж байна.

ХҮСНЭГТ 4.2. ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010, 2015 ОН

Аймаг, нийслэл	Хүн ам (мян.хүн)		2015 2010 %	Дүнд эзлэх хувь	
	2010	2015		2010	2015
БҮГД	2 647.5	2 990.2	12.9	100.0	100.0
Архангай	84.1	91.8	9.1	3.2	3.1
Баян-Өлгий	85.2	97.8	14.8	3.2	3.3
Баянхонгор	75.7	83.6	10.4	2.9	2.8
Булган	53.1	59.7	12.3	2.0	2.0
Говь-Алтай	53.2	56.	5.3	2.0	1.9
Дорноговь	57.9	63.1	9.0	2.2	2.1
Дорнод	68.9	76.4	10.9	2.6	2.6
Дундговь	38.6	44.2	14.5	1.5	1.5
Завхан	64.9	69.6	7.3	2.5	2.3
Өвөрхангай	100.4	111.9	11.5	3.8	3.7
Өмнөговь	60.9	61.4	0.8	2.3	2.1
Сүхбаатар	51.1	58.8	15.1	1.9	2.0
Сэлэнгэ	95.8	104.7	9.3	3.6	3.5
Төв	83.8	89.8	7.1	3.2	3.0
Увс	72.9	80.4	10.3	2.8	2.7
Ховд	76.3	83.1	8.9	2.9	2.8
Хөвсгөл	114.3	127.4	11.5	4.3	4.3
Хэнтий	65.3	72.3	10.8	2.5	2.4
Дархан-Уул	90.6	97.7	7.8	3.4	3.3
Улаанбаатар	1 154.3	1 345.5	16.6	43.6	45.0
Орхон	87.1	98.8	13.4	3.3	3.3
Говьсүмбэр	13.1	16.3	24.5	0.5	0.5

Хот, суурингууд эрүүл мэнд, боловсрол болон ахуйн үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр олох найдвартай газар болж, хүмүүс ихээр татагдаж байгаа нь хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

Манай улсын нийт суурин хүн амын 68 хувь нь хотод, 32 хувь нь хөдөө суурьшсан байна.



ХҮСНЭГТ 4.3.1. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Бүс нутаг	Хот		Хөдөө	
	Мян.хүн	Бүсийн хүн амд эзлэх хувь	Мян.хүн	Бүсийн хүн амд эзлэх хувь
БҮГД	2 033.1	68.0	9 57.1	32.0
Баруун	125.7	32.5	261.3	67.5
Хангай	236.7	41.3	336.4	58.7
Төв	238.1	49.9	239.1	50.1
Зүүн	87.1	42.0	120.4	58.0
Улаанбаатар	1 345.5	100.0	-	-

Аймгуудын хотжилтын түвшин хоорондоо нэлээд ялгаатайгаас бүсийн хотжилтын түвшин харьцангуй өөр байна. Зүүн бүсийн хотжилтын түвшин хамгийн бага өсөлтийн хувьтай байгаа бөгөөд 2010 оныхоос нийт хүн амд эзлэх хотын хүн ам 3.9 пунктээр буурсан. Харин Төвийн бүсийн хотжилтын түвшин хамгийн их байгаа бөгөөд нийт хүн амд эзлэх хотын хүн ам 1.9 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 4.3.2. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ХОТ, ХӨДӨӨ,
ХУВИАР, 2010, 2015 ОН, МЯН.ХҮН

Бүс нутаг	2010		2015		Өсөлтийн хувь	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
БҮГД	1 798.1	849.4	2 033.1	957.1	13.1	12.7
Баруун	122.3	230.1	125.7	261.3	2.8	13.5
Хангай	225.1	289.6	236.7	336.4	5.2	16.2
Төв	211.4	229.2	238.1	239.1	12.6	4.3
Зүүн	84.9	100.4	87.1	120.4	2.6	19.9
Улаанбаатар	1 154.3	-	1 345.5	-	16.6	-

Хүн амын суурьшлаар харвал Улаанбаатар хотын дараа Төвийн бүс нутаг хотжилт хамгийн өндөр бүс болжээ. Тухайлбал, хотын хүн амын эзлэх хувь төмөр замын дагуу байрладаг Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр аймгуудын нийт хүн амын 70-аас дээш хувь нь төв сууринд амьдарч байна. Харин Төв, Завхан, Архангай аймгуудын хотжилт 24-өөс доош хувьтай байна.




ХҮСНЭГТ 4.4. ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Бүс нутаг	Хот		Хөдөө	
	Мян.хүн	Аймаг, нийслэлийн хүн амд эзлэх хувь	Мян.хүн	Аймаг, нийслэлийн хүн амд эзлэх хувь
Бүгд	2 033.1	68.0	957.1	32.0
Архангай	21.2	23.1	70.5	76.9
Баян-Өлгий	34.9	35.7	62.9	64.3
Баянхонгор	29.6	35.4	54.0	64.6
Булган	15.0	25.1	44.7	74.9
Говь-Алтай	19.3	34.5	36.7	65.5
Дорноговь	38.9	61.6	24.2	38.4
Дорнод	42.9	56.1	33.5	43.9
Дундговь	14.3	32.4	29.9	67.6
Завхан	15.9	22.9	53.7	77.1
Өвөрхангай	35.0	31.2	77.0	68.8
Өмнөговь	20.7	33.7	40.7	66.3
Сүхбаатар	19.7	33.4	39.1	66.6
Сэлэнгэ	55.8	53.3	48.9	46.7
Төв	15.9	17.8	73.8	82.2
Увс	27.7	34.4	52.7	65.6
Ховд	27.9	33.5	55.2	66.5
Хөвсгөл	41.0	32.2	86.4	67.8
Хэнтий	24.6	34.0	47.8	66.0
Дархан-Уул	80.7	82.6	17.0	17.4
Улаанбаатар	1 345.5	100.0	0.0	0.0
Орхон	95.0	96.2	3.8	3.8
Говьсүмбэр	11.9	72.9	4.4	27.1

Хүн амын суурьшил ихтэй Төв, Завхан, Архангай, Булган зэрэг аймгуудын хотын хүн амын эзлэх хувийн жин бага, хөдөөгийн хүн амын эзлэх хувийн жин 70-аас их байна. Энэ нь эдгээр аймгийн нутаг дэвсгэр байгаль, цаг уурын таатай нөхцөлд оршдогтой холбоотой байж болох юм. Төв аймаг өөрийн гэсэн онцлогтой. Нийслэл хот өргөжих тутам түүний хил хязгаар өөрчлөгдсөн ч Төв аймгийн хөдөөгийн хүн амын эзлэх хувь бараг хэвээрээ хадгалагдсан байна. Гэхдээ Төв аймгийн иргэд аймгийн төв рүүгээ шилжихийг гол болгохгүй нийслэлд шууд шилжиж байгаа онцлог ч бас бий юм.

Аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жин Хэнтий аймагт 12 пункт, Өвөрхангайд 6.7 пункт, Ховдод 4.6 пунктээр буурсан бол Сэлэнгэд 4.2 пункт, Дорноговьд 3 пункт, Өмнөговьд 2.8 пунктээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 4.1. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ



ХҮН АМЫН НЯГТРАЛ

Улс төр, соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газарзүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшил, улмаар хүн амын нягтралд нөлөөлдөг. Бүс нутаг, аймаг, нийслэлийн хүн амын нягтралд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлс нь шилжих хөдөлгөөн юм.

Монгол Улсын нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 2010 онд 1.7 хүн ногдож байсан бол 2015 онд 0.2 пунктээр өсч 1.9 болов. Манай улс дэлхийн хамгийн сийрэг суурьшилтай орны нэг хэвээр байна.


ХҮСНЭГТ 4.5. СУУРИН ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, БҮС НУТАГ, ХУВИАР, 2015 ОН

Бүс	Хүн ам		Нутаг дэвсгэр		1 км ² -т ногдох хүн
	Мян. хүн	Дүнд эзлэх хувь	Мян.км ²	Дүнд эзлэх хувь	
БҮГД	2990.2	100.0	1564.1	100.0	1.9
Баруун	387.0	12.9	415.3	26.6	0.9
Хангай	573.1	19.2	384.3	24.6	1.5
Төв	477.2	16.0	473.6	30.3	1.0
Зүүн	207.5	6.9	286.2	18.3	0.7
Улаанбаатар	1 345.5	45.0	4.7	0.3	286.3

Улаанбаатар хот хүн амын нягтралаараа хамгийн өндөр буюу нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 2010 онд 246 хүн ногдож байснаа 2015 онд 286 болж, 16.6 хувиар өсчээ. Улаанбаатар хот Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг атлаа хүн амын 45 хувь нь оршин сууж байгаа төдийгүй энэ байдал цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Хангай болон Төвийн бүс нутагт хот, хот маягийн суурин олон байдагтай холбоотойгоор Баруун болон Зүүн бүсийг бодвол харьцангуй нягтрал ихтэй байна. Харин байгаль, цаг уурын харьцангуй тааламжтай нөхцөл бүхий Хангайн бүсэд нэг хавтгай дөрвөлжин квадрат километр 1.5 хүн ногдож байгаа нь Зүүн бүсээс 2 дахин их, Баруун бүсээс 1.6 дахин их байна.

ЗУРАГ 4.2. СУУРИН ХҮН АМЫН НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2015 ОН



Аймгуудын хүн амын нягтрал нь суурьшлын нэн сонирхолтой дүр төрхийг харуулна. Улаанбаатар хотоос гадна Орхон (нэг хавтгай дөрвөлжин квадрат километрт 123 хүн), Дархан-Уул аймгийн (нэг хавтгай дөрвөлжин квадрат километрт 29 хүн) хүн амын нягтрал бусад аймгаас хамгийн өндөр байна.

ХҮСНЭГТ 4.6. ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010, 2015 ОН

Аймаг, нийслэл	2010			2015		
	Мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²	Мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²
Бүгд	2 647.5	100.0	1.7	2 990.2	100.0	1.9
Архангай	84.1	3.2	1.5	91.8	3.1	1.7
Баян-Өлгий	85.2	3.2	1.9	97.8	3.3	2.1
Баянхонгор	75.7	2.9	0.7	83.6	2.8	0.7
Булган	53.1	2.0	1.1	59.7	2.0	1.2
Говь-Алтай	53.2	2.0	0.4	56.0	1.9	0.4
Дорноговь	57.9	2.2	0.5	63.1	2.1	0.6
Дорнод	68.9	2.6	0.6	76.4	2.6	0.6
Дундговь	38.6	1.5	0.5	44.2	1.5	0.6
Завхан	64.9	2.5	0.8	69.6	2.3	0.8
Өвөрхангай	100.4	3.8	1.6	111.9	3.7	1.8
Өмнөговь	60.9	2.3	0.4	61.4	2.1	0.4
Сүхбаатар	51.1	1.9	0.6	58.8	2.0	0.7
Сэлэнгэ	95.8	3.6	2.3	104.7	3.5	2.5
Төв	83.8	3.2	1.1	89.8	3.0	1.2
Увс	72.9	2.8	1.0	80.4	2.7	1.2
Ховд	76.3	2.9	1.0	83.1	2.8	1.1
Хөвсгөл	114.3	4.3	1.1	127.4	4.3	1.3
Хэнтий	65.3	2.5	0.8	72.3	2.4	0.9
Дархан-Уул	90.6	3.4	27.5	97.7	3.3	29.6
Улаанбаатар	1 154.3	43.6	245.6	1 345.5	45.0	286.3
Орхон	87.1	3.3	108.9	98.8	3.3	123.4
Говьсүмбэр	13.1	0.5	2.4	16.3	0.5	3.0

Аймгуудын хүн амын нягтрал шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор ерөнхийдөө буурах хандлагатай ажээ. Дээр дурдсан 3 аймаг, хотын дараагаар тэдгээртэй харьцуулахад бага нягтралтай, нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 2-3 хүн ногдож байгаа Баян-Өлгий, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгууд орж байна. Харин Өмнөговь, Дорноговь, Дорнод, Дундговь болон Баруун бүсийн Говь-Алтай аймагт хүн амын нягтрал хамгийн сийрэг, нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 0.4-0.6 хүн ногдож байна.

ДҮГНЭЛТ

Манай улсын нийт суурин хүн амын 68 хувь нь нийслэл, аймгийн төв, тосгонд оршин сууж байгаа бол 32 хувь нь сумын төв, хөдөөд оршин сууж байна. Хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 45 хувь нь Улаанбаатар хот, 19.2 хувь нь Хангайн бүс, 16 хувь нь Төвийн бүс, 12.9 хувь нь Баруун бүс, 6.9 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна. Нийт хүн амд эзлэх Улаанбаатар хотын хүн амын суурьшил нь 2010 оныхоос 1.4 пунктээр өссөн бол бусад бүс нутгуудад буурсан байна.

Монгол Улсын хүн амын нягтрал 2010 онд нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 1.7 хүн ногдож байсан бол 2010 онд 1.9 болж өссөн нь үндэсний түвшинд хүн амын ердийн цэвэр өсөлтийн нөлөө юм. Аймаг, нийслэлийн хүн амын нягтралын өөрчлөлтөд дээр дурдсан хүчин зүйлсээс гадна гадаад, дотоод шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2010-2015 оны хооронд 16.6 хувь, Говьсүмбэр аймаг 23.5 хувь, Сүхбаатар 19.1 хувь, Дундговь аймгийнх 18.3 хувь болж өссөн нь мөн л шилжих хөдөлгөөнтэй холбоотой.

ТАВДУГААР БҮЛЭГ

ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ,
НӨХЦӨЛ

СУУЦНЫ ТӨРӨЛ


Хүний амьдралын анхдагч хэрэгцээ, эрүүл энх, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол орон сууц юм. Төр, засгийн бодлогын нэг хэсэг нь хүн амаа орон сууцаар хангаж, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд чиглэдэг.

Монгол Улс хүн амын 1969 оны тооллогоос эхлэн орон сууцны тооллогыг хамтатган зохион байгуулж, орон сууцны нөхцөлийн талаарх мэдээллийг цуглуулж, бодлого, хөтөлбөртөө оруулж ирсэн. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын орон сууц, түүний нөхцөлийн талаарх асуулгын агуулга, бүтэц нь өмнөх тооллогуудынхтай адил. Энэ удаа байшин болон Монгол ард түмний уламжлалт сууц – гэрийн талаарх мэдээллийг тус тусад нь авч үзэв.

Тооллогод хэрэглэсэн сууц гэдэг ойлголт өргөн утгаараа тоолох үед хүний амьдарч байгаа зориулалтын болон зориулалтын бус бүх төрлийн сууцыг хамардаг. Нөгөө талаар хүн амын амьдарч байгаа сууцны нөхцөл ямар байгааг тодорхойлж, орон сууцжуулах бодлого, хөтөлбөрийн үр өгөөжийг үнэлэх зорилго агуулж байсан тул сууцны нөхцөл, дэд бүтцийн хангамжийн үзүүлэлтийг гаргахад чиглэгдсэн. Гэхдээ орон сууцны фондын тооллогыг явуулаагүй тул тооллогын үр дүнд хүн амьдардаггүй сууцны тоо, сууцны насжилт, ханын болон дээврийн материал, дэд бүтцийн талаарх мэдээллийг гаргах боломжгүй. Тухайлбал, манай улс хичнээн орон сууцны болон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, эсвэл гэртэй вэ гэсэн үзүүлэлтийг тодорхойлох бололцоогүй юм.

Тоолох үед өрхийн амьдарч буй сууцыг хүн амьдрах зориулалтаар нь гэр, байшин, бусад сууц гэж ангилсан. Өөрөөр хэлбэл, бусад сууц гэсэн ангиллын сууцууд хүний амьдрах тав тухтай орчинг хангах шаардлагад нийцэхгүй гэсэн агуулгыг илэрхийлнэ (сууцны төрлийн тодорхойлолтыг энэ номын 1 дүгээр бүлгийн “Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт” гэсэн хэсгээс үзнэ үү). Дараагийн онцлон тэмдэглэх асуудал бол нэгээс илүү сууцтай өрхүүдийн хувьд хүйтний улиралд амьдардаг үндсэн сууцаар нь асуулгыг асуусан болно.

ЗУРАГ 5.1. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2015 ОН



Орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 45.4 хувь нь үндэсний уламжлалт сууц - гэрт, 54.2 хувь нь байшинд, 0.4 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 0.2 пунктээр, байшинд амьдардаг өрхийн хувь 0.6 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 5.1. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	859.1	100.0	579.3	100.0	279.8	100.0
Гэр	389.9	45.4	187.8	32.4	202.1	72.2
Байшин	465.3	54.2	389.2	67.2	76.1	27.2
Бусад	3.9	0.4	2.3	0.4	1.6	0.6

Хот, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байна. Хотод нийт өрхийн 67.2 хувь нь байшинд, 32.4 хувь нь гэрт амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь өсч, гэрт амьдардаг өрхийнх буурчээ. Хөдөөгийн өрхийн 72.2 хувь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 1.3 пунктээр өсч, харин байшинд амьдардаг өрхийн хувь 1.3 пунктээр буурсан байна.

Байшинг төрлөөр харьцуулалт хийхэд орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 24.8 хувийг эзэлж, 2010 оныхоос 3.7 пунктээр өссөн байна. Харин сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 29.4 болж 2010 оныхоос 1.6 пунктээр буурч, орон сууцны байшинд суудаг өрхийн хувийн жин 2015 онд 27.8 болж 2010 оныхоос 1.6 пунктээр буурсан байна. Ийнхүү орон сууцанд суух өрхийн тоо өссөн нь төрөөс орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэнтэй холбоотой байх талтай юм. Нийт өрхийн 0.5 хувь нь бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа нь 2010 оны түвшинтэй ижил байна.

ХҮСНЭГТ 5.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2015 ОН

Сууцны төрөл	2010		2015	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	859.1	100.0
Гэр	322.8	45.2	389.9	45.4
Байшин	382.8	53.6	465.3	54.2
Орон сууцны байшин	152.3	21.3	212.7	24.8
Бие даасан тохилог сууц	3.8	0.5	4.2	0.5
Сууцны тусдаа байшин	209.9	29.4	238.4	27.8
Нийтийн байр	16.7	2.3	9.9	1.2
Бусад сууц	8.2	1.1	3.9	0.5

Хөдөөгийн өрхийн 83.6 хувь болон аймгийн төвийн өрхийн 36.4 хувь нь гэрт, сумын төвийн өрхийн 40.0 хувь болон тосгоны өрхийн 41.0 хувь нь сууцны тусдаа байшинд, нийслэлд амьдардаг өрхийн 41.0 орчим хувь нь орон сууцны байшинд амьдарч байгаа нь байршлынхаа хувьд хамгийн өндөр үзүүлэлтүүд байна.

ХҮСНЭГТ 5.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, БАЙРШИЛ, ХУВИАР, 2015 ОН

Сууцны төрөл	Бүгд	Нийслэл	Аймгийн төв	Тосгон	Сумын төв	Хөдөө
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэр	45.4	30.4	36.4	34.0	51.2	83.6
Байшин	54.2	69.4	63.0	64.0	47.9	15.9
Орон сууцны байшин	24.8	41.0	26.4	19.2	5.7	0.5
Бие даасан тохилог сууц	0.5	0.4	1.2	0.5	0.2	0.0
Сууцны тусдаа байшин	27.8	27.0	33.8	41.0	40.0	15.1
Нийтийн байр	1.2	1.0	1.6	3.3	2.1	0.3
Бусад сууц	0.5	0.2	0.7	2.0	0.9	0.4

ОРОН СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР

Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ, цаашид орон сууцны эрэлт, хэрэгцээ ямар байх вэ зэрэг асуултад тодорхой хэмжээгээр хариулт өгөх үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм. Улсын хэмжээнд нийт өрхийн 2.5 хувь буюу 17.7 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Эдгээрийн 10.1 мянга нь хотын өрхүүд юм. Хөдөөд энэ үзүүлэлт харьцангуй бага байгаа нь орон сууцны хэрэгцээг гол төлөв шинэ гэр, байшин барьж хангах боломжтой байдагтай холбоотой болов уу.

ХҮСНЭГТ 5.4. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Эзэмшлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
Өөрийн	841.4	97.9	566.3	97.8	275.2	98.3
Бусдын сууцанд түрээстэй	13.2	1.5	10.1	1.8	3.0	1.1
Бусдын сууцанд түрээсгүй	4.5	0.5	2.9	0.5	1.6	0.6

ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсонтой холбоотой. Тиймээс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хангамж, хүрэлцээг тодорхойлж, цаашид холбогдох бодлого, хөтөлбөр боловсруулах суурь мэдээлэл бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм.

ХҮСНЭГТ 5.5. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Мян. өрх	Дүнд эзлэх хувь	Мян. өрх	Дүнд эзлэх хувь	Мян. өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	859.1	100.0	579.3	100.0	279.8	100.0
Төвлөрсөн систем	677.8	78.9	566.3	97.7	111.5	39.9
Дизель станц	2.5	0.3	1.1	0.2	1.4	0.5
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	156.7	18.2	7.5	1.3	149.2	53.3
Бага оврын цахилгаан үүсгүүр	15.4	1.8	2.2	0.4	13.1	4.7
Цахилгааны эх үүсвэргүй	6.8	0.8	2.3	0.4	4.5	1.6
ГЭР	389.9	100.0	187.9	100.0	202.1	100.0
Төвлөрсөн систем	230.7	59.2	177.2	94.3	53.5	26.5
Дизель станц	1.4	0.4	0.6	0.3	0.8	0.4
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	139.6	35.8	6.5	3.4	133.2	65.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	12.4	3.2	1.8	1.0	10.6	5.2
Цахилгааны эх үүсвэргүй	5.8	1.5	1.8	0.9	4.0	2.0
БАЙШИН	465.3	100.0	389.2	100.0	76.1	100.0
Төвлөрсөн систем	443.7	95.4	386.9	99.4	56.8	74.6
Дизель станц	1.1	0.2	0.4	0.1	0.7	0.9
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	16.8	3.6	1.0	0.3	15.8	20.7
Бага оврын цахилгаан үүсгүүр	2.9	0.6	0.4	0.1	2.5	3.3
Цахилгааны эх үүсвэргүй	0.9	0.2	0.5	0.1	0.4	0.5

Улсын хэмжээнд 6.8 мянган өрх цахилгаангүй байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 3.4 дахин буурсан үзүүлэлт юм. Энэхүү цахилгаангүй өрхийн бууралтад хөдөө гэрт амьдардаг сэргээгдэх эрчим хүч ашигладаг өрх 42.4 мянган өрхөөр буюу 31.8 хувь нэмэгдэж, цахилгааны эх үүсвэргүй өрхийн хувь 6.0 мянган өрх буюу 36.1 хувиар буурсан нь нөлөөлсөн байх талтай.

ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Үндэсний уламжлалт сууц болох гэрт нийт өрхийн 45.4 хувь нь амьдарч байгааг дээр тэмдэглэсэн.

ХҮСНЭГТ 5.6. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Ханын тоо	Бүгд		Хот		Хөдөө	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	389.9	100.0	187.9	100.0	202.1	100.0
5-хүртэлх	81.0	20.8	37.1	19.7	43.9	21.7
5	260.3	66.8	133.6	71.1	126.7	62.7
6	38.8	9.9	11.1	5.9	27.7	13.7
6-аас дээш	9.9	2.5	6.1	3.2	3.8	1.9

Гэрт амьдардаг өрхийн 66.8 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байгаагаас үзэхэд таван ханатай гэр манай хүн амын түгээмэл сууц гэж ойлгогдоно. Гэрийн ханын тоогоор талбайн хэмжээг тооцож болох хэдий ч аймаг орон нутаг, үндэстэн угсаатны уламжлалт зан заншилтай холбоотойгоор ханын толгойн тоо, зууравчны хэмжээнээс хамаарч, гэрийн хэмжээ бүс нутгуудад өөр өөр байдгийг судлаачид анхаарах нь зүйтэй.

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлт болох хатуу хог хаягдал болон бохир ус зайлуулах хэлбэр гэсэн үзүүлэлтийг тухайн өрхөөс асуусан бөгөөд үр дүнг нь нэгтгэвэл дараах байдалтай байна.

ХҮСНЭГТ 5.7. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Үзүүлэлт	Бүгд	Хот	Хөдөө
ХАТУУ ХОГ ХАЯГДЛАА ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР	100.0	100.0	100.0
Үйлчилгээний байгууллагаар	45.2	85.7	7.5
Өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт	17.2	8.0	25.8
Тогтсон газар байхгүй	37.6	6.3	66.7
БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР	100.0	100.0	100.0
Цооногт асгадаг	53.9	81.0	28.7
Задгай асгадаг	46.1	19.0	71.3

Хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх хотын нийт өрхийн 6.3 хувь, хөдөөгийн нийт өрхийн 66.7 хувь, бохир усаа задгай асгадаг өрх хотын нийт өрхийн 19.0 хувь, хөдөөгийн нийт өрхийн 71.3 байгаа нь орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлж байгааг анхаарч, цаашид гүнзгийрүүлэн судалж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай. Хатуу хог хаягдал болон бохир ус зайлуулах тогтсон газар байхгүй байх нь хөрсний бохирдол, хүн амд халдварт өвчин тархах магадлалыг нэмэгдүүлж байна.

БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

СУУЦНЫ БАГТААМЖ

Байшинд амьдардаг өрхийн сууцны талбайн хэмжээ, өрөөний тоог тооллогын асуулгад оруулсан нь сууцны зай талбай оршин суугчдын эрүүл ахуйн шаардлагыг хэр зэрэг хангаж байгаа болон аймаг, бүс нутгийг жиших, гадаад орнуудын ижил төрлийн үзүүлэлттэй зэрэгцүүлж, бодлого төлөвлөлтөд ашиглах зорилготой.

ХҮСНЭГТ 5.8. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Талбайн хэмжээ (м.кв)	Бүгд		Хот		Хөдөө	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	465.3	100.0	389.2	100.0	76.1	100.0
20 хүртэл	43.9	9.4	37.3	9.6	6.6	8.6
21-30	99.0	21.3	84.6	21.7	14.5	19.0
31-40	91.5	19.7	77.0	19.8	14.5	19.1
41-50	83.5	18.0	68.3	17.5	15.2	20.0
51-60	52.2	11.2	42.5	10.9	9.7	12.7
61-70	31.7	6.8	24.3	6.2	7.5	9.8
71-80	20.3	4.4	16.7	4.3	3.6	4.8
81+	43.1	9.3	38.6	9.9	4.5	6.0

Байшинд амьдардаг нийт өрхийн 9.4 хувь нь 20 хүртэлх квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 3.9 хувиар буурч, 21-40 квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа өрх 41.0 болж өмнөх тооллогын үеийнхээс 1.0 пунктээр, 40 ба түүнээс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа өрх 3.0 пунктээр тус тус өссөн байна.

Нийт өрхийн 49.7 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай байшинд сууж байгаагийн 29.2 хувь нь 41-60 квадрат метр талбайтай сууцанд амьдарч байна. Энэхүү сууцны талбайн тархалт нь хот, хөдөөгийн өрхийн хувьд мөн адил харагдаж байна.

ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ

Байшинд амьдардаг өрхийн 47.5 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 3.7 пунктээр өссөн байна. Хотын төвлөрсөн халаалттай байшинд амьдардаг өрхийн хувь 3.2 пункт, хөдөөд 2.7 пунктээр нэмэгджээ. Харин иргэд сууцаа ердийн галлагаагаар халааж байгаа хувь хотод 1.9 пунктээр буурч, хөдөөд 0.3 пунктээр өссөн. Энэ бүхнээс үзэхэд өнгөрсөн 5 жилийн хугацаанд орон сууцжуулах хөтөлбөр, гэр хорооллын дахин төлөвлөлтийн арга хэмжээнүүд тодорхой хэмжээнд үр өгөөжтэй болсныг харуулж байна.

ХҮСНЭГТ 5.9. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2015 ОН

Халаалтын төрөл	2010			2015		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн	43.8	51.6	7.2	47.5	54.8	9.9
Төвлөрсөн бус	5.9	6.3	4.1	4.6	4.6	4.4
Нам даралтын зуух	5.3	5.6	3.6	3.7	3.7	3.9
Цахилгаан халаагуур	0.6	0.7	0.5	0.8	0.9	0.5
Ердийн галлагаа	50.2	42.1	88.7	48.0	40.6	85.7

Халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн хувь 43.3 байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 4.8 пунктээр нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт хотод 50.5 хувь, хөдөөд 6.4 хувь байна. Байшинд амьдардаг өрхийн 51.9 хувь буюу 241.6 мянган өрх зөөврийн ус хэрэглэж байгаагийн дотор хотын 173.2 мянган өрх байна. Байшинд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн хувь өмнөх тооллогоос 4.9 пунктээр буурсны дотор хотод 4.4 пункт, хөдөөд 3.9 пунктээр тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 5.10. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2015 ОН

Үзүүлэлт	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0
Төвлөрсөн усан хангамж	43.7	51.0	6.8
Халуун, хүйтэн устай	43.3	50.5	6.4
Зөвхөн хүйтэн устай	0.4	0.4	0.4
Төвлөрсөн бус усан хангамж	56.3	49.0	93.2
Бие даасан систем	4.3	4.5	3.3
Халуун, хүйтэн устай	4.0	4.3	2.5
Зөвхөн хүйтэн устай	0.4	0.3	0.8
Зөөврийн	51.9	44.5	89.9

